

**“ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ” ХК-ИЙН 2018 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**


*/Хугацаа: 2018 оны 01 дүгээр сарын 01-ний
өдрөөс 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр/*

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Оршил

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь 2018 оны эхний хагас жилд үйл ажиллагаандаа Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 02/01 дугаар тогтоолоор батлагдсан компанийн Бизнес төлөвлөгөө, Гүйцэтгэх захирлын 2018 оны 04/17 дугаар тушаалаар батлагдсан компанийн 2018 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг тус тус удирдлага болгон ажиллалаа.

1.2. Бүтэц, зохион байгуулалт



ХОЁР. ДАВХАР ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. МИД-ын үйл ажиллагаа, борлуулалтын орлого

Ард даатгал ХХК, Бодь даатгал ХХК, Миг даатгал ХХК, Монгол даатгал ХХК, Монре даатгал ХХК, Номин даатгал ХХК, Практикал даатгал ХХК, Тэнгэр даатгал ХХК, Хаан даатгал ХХК гэсэн 9 даатгалын компанитай МИД-ын Алдагдал зогсоох давхар даатгалын гэрээ байгуулж, МИД-ын 2018 оны борлуулалтын улирлыг 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлүүлээ.

Оролцогч даатгалын компаниудын 2018 оны борлуулалтын төлөвлөгөөг авч нэгтгэн, давхар даатгалын хураамжийн тооцооллыг гаргаж, 2018 онд МИД-д оролцогч даатгалын компаниуд гарын үсэг зурж баталгаажуулсан.

МИД-ын тухай хуулийн дагуу 3 жил тутамд босго үзүүлэлтийг шинэчлэх ба үүнтэй холбогдуулан Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 2015 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 78/90 дүгээр тушаалаар батлагдсан “Малын индексжүүлсэн даатгалын хураамжийн хэмжээг тооцох журам”-ын дагуу МИД-ын хураамжийн хэмжээг тооцоолсон бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 33 дугаар тогтоолоор МИД-ын босго үзүүлэлт батлагдсан. Босго үзүүлэлт нь тухайн аймгийн малын хорогдлын эрсдэлээс хамааран 5 болон 6 хувьтай байна.

Монгол Улсын Үндэсний Статистикийн газраас судлан гаргасан малын үнэд үндэслэн 2018 оны МИД-ын борлуулалтын малын үнийг тооцоолон гаргав.

Аймгийн код	Аймгийн нэр	Хонь (₮)	Ямаа (₮)	Үхэр (₮)	Адуу (₮)	Тэмээ (₮)
01	Архангай	110,000.00	80,000.00	650,000.00	550,000.00	850,000.00
02	Баян-Өлгий	90,000.00	70,000.00	500,000.00	900,000.00	850,000.00
03	Баянхонгор	110,000.00	80,000.00	650,000.00	500,000.00	750,000.00
04	Булган	110,000.00	80,000.00	800,000.00	650,000.00	850,000.00
05	Говь-Алтай	120,000.00	80,000.00	850,000.00	750,000.00	1,000,000.00
06	Дорноговь	125,000.00	90,000.00	1,000,000.00	600,000.00	950,000.00
07	Дорнод	100,000.00	80,000.00	900,000.00	600,000.00	750,000.00
08	Дундговь	130,000.00	100,000.00	1,100,000.00	900,000.00	1,200,000.00
09	Завхан	120,000.00	70,000.00	800,000.00	550,000.00	900,000.00
10	Өвөрхангай	120,000.00	80,000.00	800,000.00	550,000.00	950,000.00
11	Өмнөговь	150,000.00	100,000.00	850,000.00	750,000.00	1,000,000.00
12	Сүхбаатар	110,000.00	70,000.00	900,000.00	600,000.00	700,000.00
13	Сэлэнгэ	125,000.00	100,000.00	900,000.00	700,000.00	800,000.00
14	Төв	120,000.00	90,000.00	850,000.00	700,000.00	900,000.00
15	Увс	110,000.00	70,000.00	700,000.00	700,000.00	900,000.00
16	Ховд	110,000.00	80,000.00	700,000.00	600,000.00	850,000.00
17	Хөвсгөл	100,000.00	70,000.00	700,000.00	550,000.00	800,000.00
18	Хэнтий	100,000.00	90,000.00	750,000.00	700,000.00	750,000.00
21	Орхон	130,000.00	80,000.00	800,000.00	650,000.00	850,000.00
22	Дархан-Уул	150,000.00	90,000.00	900,000.00	700,000.00	800,000.00
23	Говь-Сүмбэр	130,000.00	80,000.00	500,000.00	550,000.00	950,000.00
24	Улаанбаатар	140,000.00	80,000.00	750,000.00	500,000.00	900,000.00

Хаан болон Төрийн банкттай хамтран ажиллах гэрээг сунгаж, нэмэлт өөрчлөлтийг оруулж батлуулав.

Төрийн болон Хаан банкттай МИД-ыг зуучлан борлуулах ажлын хүрээнд "МИД-ын зуучлагчаар ажиллах журам"-ыг оролцогч талууд /9 даатгалын компани/-аас санал авсны үндсэн дээр шинэчлэн боловсруулж Гүйцэтгэх захирлын 2018 оны 04/32 дугаар тушаалаар батлан мөрдөж ажилласан.

МИД-ын борлуулалтыг нэмэгдүүлэх, сурталчлах, таниулах ажлын хүрээнд:

- 2018 оны хуанли хэвлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтыг зарлаж хамгийн бага үнийн санал ирүүлсэн Эс Пи Ар ХХК хэвлэлийн газрыг сонгон, нийт 10,000 ширхгийг хэвлүүлэн даатгалын компаниудад тараасан.
- МИД-ын товхимол /гарын авлага/ хэвлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, хамгийн бага үнийн санал ирүүлсэн Эм Ти Эй Интернэшнл ХХК-ийг сонгон, 10,000 ширхгийг хэвлүүлэн даатгалын компаниудад тараалаа.
- Орон нутгийн нийт 600 чиглэлийн автобуснуудад МИД-ын богино хэмжээний дүрст сурталчилгаа /шторк/-г явуулсан.
- МИД-ын тухай 16 үзэгдэлт радио цуврал жүжиг бэлтгэн МҮОНР-оор түгээв.
- МИД-ын тухай мэдээлэл агуулсан 30,000 ширхэг тараах материал /брошюр/ хэвлүүлэн, орон нутагт тараалаа.
- МИД-ын төлөөлөгч нарт зориулж МИД-ын программ ашиглах болон хаалтын үйл ажиллагаанд зориулсан сургалтын видео хичээл хийв.
- МИД-ын 2018 оны борлуулалтын үйл ажиллагаатай танилцах, идэвхжүүлэх, малчдад компанийн үйл ажиллагааг сурталчлан таниулах, даатгалын компани болон зуучлагч банкнуудтай уулзах зорилгоор төв, зүүн болон баруун бүсийн аймгуудаар албан томилолтоор ажиллав.
- МИД-ын үйл ажиллагааг идэвхжүүлэх, түүний ач тусыг малчдад сурталчлан таниулах, борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор Говь-Алтай, Увс аймагт хөлсөөр ажиллах гэрээгээр ажилтнуудыг ажиллуулж, сар бүрийн ажлын тайланг хүлээн авч, дүгнэн ажиллалаа.
- Хаан болон Төрийн банкны борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор банкнуудаас дотооддоо зохион байгуулж буй уралдаанд манай компанийн зүгээс дэмжлэг үзүүлэн оролцож, талуудаас уралдааныг дүгнэсэн тайланг хүлээн авлаа.
- МИД-ын 2018 оны борлуулалт хийх эрх авсан нийт даатгалын төлөөлөгчдийн дунд “МИД-ын Манлай даатгалын төлөөлөгч” болон “Аймгийн тэргүүний даатгалын төлөөлөгч” уралдааныг зохион байгуулж удирдамжийн дагуу шалгаруулж, өргөмжлөл мөнгөн шагналыг гардуулсан. “МИД-ын Манлай даатгалын төлөөлөгч”-өөр Тэнгэр даатгал ХХК-ийн төлөөлөгч Ё.Должин, “Аймгийн тэргүүний даатгалын төлөөлөгч”-өөр Ард даатгал ХХК-ийн төлөөлөгч А.Ганзориг тэргүүтэй 9 даатгалын компаниас нийт 19 даатгалын төлөөлөгч шалгарсан.
- Монгол Улсын Шадар сайдын ЗГ-02/139 албан тоотоор хүргүүлсэн албан даалгаврын биелэлтийг аймаг, орон нутагт хэрхэн хэрэгжүүлсэн талаар тайланг Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Дорноговь, Өмнөговь, Сүхбаатар, Завхан, Төв, Хэнтий, Орхон гэсэн 10 аймаг ирүүлсэн ба Баян-Өлгий, Булган, Говьсүмбэр, Дархан-Уул, Дундговь, Дорнод, Өвөрхангай, Сэлэнгэ, Увс, Ховд, Хөвсгөл гэсэн 11 аймаг ирүүлээгүй. Ирүүлсэн тайланг аймаг бүрээр эмхэтгэн бичиж, Монгол Улсын Шадар сайдад хүргүүлэн тайлагналаа.
- Даатгагчдын холбоонд 2018 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр даатгалын сургагч багш нарт МИД-ын сургалт хийлээ.
- Малчдын Улсын зөвлөгөөнд оролцон, 800 гаруй малчдад МИД-ын талаар танилцуулга хийсэн.
- Харилцагч байгууллагынхаа саналаар Төрийн банкны орон нутгийн нийт салбарын ажилтнууд болон Хаан даатгал ХХК, Санхүүгийн зохицуулах хорооны зуучлалын эрх олгох сургалтад МИД-ын талаар сургалт хийв.
- 2018 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс 2 дугаар сарын 16-ын өдрийг дуустал Төрийн банкнаас зохион байгуулсан “Тооцооны төв хариуцсан мэргэжилтнүүдэд даатгалын үйл ажиллагааны нэгдсэн сургалт”-д оролцож МИД болон түүний холбогдох хууль, дүрэм, журам, зах зээлийн талаарх сургалт хийсэн.
- Зуучлалын гэрээнд заасны дагуу зуучлагч Хаан болон Төрийн банктай сар бүр МИД-ын борлуулалтын тооцоо нийлэн, зуучлалын хөлсийг шилжүүлэн ажиллалаа.

- МИД-ын борлуулалтын явцын мэдээг сар бүр оролцогч даатгалын компани болон зуучлагч банкнуудад хүргэсэн.
- МИД-д оролцогч талуудад шаардлагатай мэдээлэл сургалтыг тухай бүр нь өгч, мэдээллээр ханган зөвлөгөө өгч ажиллалаа.
- Даатгалын компани болон зуучлагч банкны МИД-ын борлуулалтыг өдөр бүр шалган хянаж, хооронд үүссэн асуудал, давхардлыг тухай бүрд хариуцсан ажилтантай холбогдон засаж залруулсан.
- МИД-ын борлуулалтыг өдөр бүр шалган хянаж, гарсан асуудлууд болон даатгалын компани, зуучлагч банкны хооронд үүссэн үл ойлголцлыг холбогдох ажилтан нартай холбогдон цаг тухай бүрд шийдэж, үүссэн давхардлыг арилгуулан ажилласан.

Борлуулалтын хаалт хийж, холбогдох сангуудыг бүрдүүлэх ажлын хүрээнд:

МИД-ын 2018 оны борлуулалтын улирлыг дуусгаж, зуучлагч банк болон даатгалын компаниудын МИД-ын программд борлуулалтаа бүртгэх ажлыг хянан зохион байгуулж, МИД-ын баталгаа болон программд гарсан алдаа зөрчил дутагдлыг бүрэн арилгаж, программыг хааж, баталгаануудыг хийн архивлан цэгцэлсэн.

МИД-ын борлуулалтыг 2018 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөр хаасан бөгөөд хаалтын өдрийн байдлаар зуучлагч Төрийн банк 12946 борлуулалт 1,074,820,000.00 /нэг тэрбум далан дөрвөн сая найман зуун хорин мянган/ төгрөгийн, Хаан банк 12931 борлуулалт 1,141,940,000.00 /нэг тэрбум нэг зуун дөчин нэгэн сая есөн зуун дөчин мянган/ төгрөгийн, даатгалын компаниуд 7841 борлуулалт 1,245,937,746.80 /нэг тэрбум хоёр зуун дөчин таван сая есөн зуун гучин долоон мянга долоон зуун дөчин зургаан төгрөг наян мөнгө/ төгрөгийн, нийт **33718** борлуулалт **3,462,697,746.80** /гурван тэрбум дөрвөн зуун жаран хоёр сая зургаан зуун ерэн долоон мянга долоон зуун дөчин зургаан төгрөг наян мөнгө/ төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлэн ажиллалаа.

МИД-ын 2019 оны борлуулалт эхлэхтэй холбоотой ажлын хүрээнд:

МИД-ын 2019 оны борлуулалтад оролцох даатгалын компаниудын төлөвлөгөөг нэгтгэн авч, Ард даатгал ХХК, Бодь даатгал ХХК, МИГ даатгал ХХК, Монгол даатгал ХХК, Монре даатгал ХХК, Номин даатгал ХХК, Практикал даатгал ХХК, Тэнгэр даатгал ХХК, Хаан даатгал ХХК гэсэн 9 даатгалын компанитай МИД-ын Алдагдал зогсоох давхар даатгалын гэрээг байгуулав.

Мөн МИД-ын 2019 оны борлуулалт эхлэхтэй холбогдон оролцогч даатгалын компани болон зуучлагч банкны мэргэжилтнүүдтэй уулзалт зохион байгууллаа. Уулзалтаар зуучлалын гэрээ байгуулах болон цаашид анхаарах асуудлын талаар ярилцан санал солилцсон. Зуучлагч Хаан болон Төрийн банк, 9 даатгалын компаниудын зуучлалын гэрээ болон зуучлагч банктай байгуулах Хамтран ажиллах гэрээ бэлэн болж, гарын үсэг зурж баталгаажих ажил хийгдэж байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргатай 2018 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр уулзлаа. Уулзалтаар ХХААХҮЯ-тай цаашид хэрхэн хамтран ажиллах, ямар чиглэл, үйл ажиллагаанд оролцох талаар санал бодлоо солилцов. Гарсан саналтай холбогдуулан тус компаниас ХХААХҮЯ руу албан тоот илгээлээ.

2.2. Газар тариалангийн даатгалын бүтээгдэхүүн

Индексжүүлсэн даатгалын загварчлалыг боловсруулах ажлын хүрээнд:

СКОР /SCOR/ олон улсын давхар даатгалын компанитай байгуулсан индексжүүлсэн даатгалыг хөгжүүлэх хамтын ажиллагааны гэрээний хүрээнд тариалангийн даатгалын загварчлал боловсруулахад шаардлагатай дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- СКОР /SCOR/ олон улсын давхар даатгалын компанид Монгол Улсын улаан буудай тариалж байгаа 86 сумдыг газрын зурган дээр тэмдэглэн, газар тариалангийн хөрсний

талаарх зургийг тус тус бэлтгэн хүргүүлсэн. Тус давхар даатгалын компаниас боловсруулсан индексжүүлсэн даатгалын загварчлалд орсон тариалангийн салбарт учрах эрсдэлүүдийн талаарх танилцуулгатай танилцаж, англи хэлнээс монгол хэл рүү орчуулсан.

- СКОР /SCOR/ олон улсын давхар даатгалын компанитай 2018 оны 01 дүгээр сарын 24, 02 дугаар сарын 01-ний өдрүүдэд индексжүүлсэн тариалангийн даатгалын загварчлалын талаарх цахим /онлайн/ уулзалт хийлээ.
- Тариалалт эхлэх өдөр, тариалалт хийж буй хөрсний төрөл, болц гүйцэх өдөр гэсэн хүчин зүйлсийн нөлөөллийг шалгасан. Үүнээс хөрсний төрөл нь ургац загварчлалын үр дүнд маш бага нөлөөтэй байсан тул цаашид загварчлалаас хассан. Тариалалт эхлэх өдрийн 5 хувилбар болон ургацын болц гүйцэх өдрийн 3 интеграл байгуулж нийт 15 хувилбараар ургацын загварчлалыг хийх саналыг СКОР /SCOR/ олон улсын давхар даатгалын компаниас тавьсан.
- ЧИРПС /CHIRPS/ хиймэл дагуулын мэдээллийн сангаас 5 км болон 12 км-ийн нарийвчлалтай хур тунадас, температур болон нарны тусгалын талаарх мэдээлэл цуглуулж тариалангийн бүс нутгийн хэмжээнд дээрх 15 хувилбар бүрд 10 жилийн түүхэн ургацын мэдээллийг загварчилсан. Үүнээс 12 км-ийн мэдээлэлд тулгуурласан ургацын загвар нь нарийвчлал муутай, нэгэн жигд байхад 5 км-ийн мэдээлэлд тулгуурласан загвар нь илүү хувирамтгай, таамаглал сайтай байсан учраас цаашид 5 км-ийн нарийвчлалтай мэдээлэл ашиглахыг зөвлөлөө.
- 5 км-ийн нарийвчлалтайгаар ургацын дүн мэдээг загварчлахад хугацаа шаардагдахаар байсан учраас загварчлалыг хугацааны хувьд оновчтой болгохын тулд зөвхөн улаан буудайн тариалан эрхэлдэг тариалангийн бүс нутгийн газрын зургийг бэлтгэхээр ажилласан. Геодези, зураг зүйн газрын Кадастрын хэлтсээс тариалангийн бүс нутаг болох Сэлэнгэ, Төв, Дархан-Уул, Булган, Дорнод, Хэнтий, Хөвсгөл, Орхон, Архангай гэсэн нийт 9 аймгийн тариалангийн зориулалтаар ашиглаж байгаа газрын зургийг бэлтгүүлэн СКОР /SCOR/ олон улсын давхар даатгалын компанийн холбогдох мэргэжилтэнд явуулсан. Бэлтгэн явуулсан нарийвчлалтай газрын зургийг ашиглан дахин дээрх 15 хувилбар бүрд 10 жилийн түүхэн ургацын мэдээллийг загварчилсан.
- СКОР /SCOR/, Зэдэкс /ZedX/ зэрэг олон улсын давхар даатгалын компанийн мэргэжилтнүүдтэй 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр хийсэн цахим уулзалтын үр дүнд ирүүлсэн индексжүүлсэн тариалангийн даатгалын загварчлалын ажлын явцын танилцуулгыг орчууллаа. Индексжүүлсэн тариалангийн даатгалын загварчлалын хүрээнд даатгуулагч Эг тариа ХХК, Алтан залаа ХХК, Их шинэстэй ХХК, Орхон хөгжил ХХК-уудын талбайн байршлын координат, түүнийг тэмдэглэсэн газрын зураг, сүүлийн 7 жилийн ургацын мэдээллийг эмхэтгэн явуулсан. Мөн СКОР /SCOR/-оос ирүүлсэн Монголын улаан буудай тариаланчдад тавих асуулгыг монгол хэл рүү орчуулан, 2018 оны даатгалд хамрагдсан 10 аж ахуйн нэгжүүдээс судалгаа авч байна.

Монгол Улсын Шадар сайдын өгсөн үүрэг даалгаврын дагуу ХХААХҮЯ-ны сайд Б.Батзоригт тариалангийн даатгалтай холбоотой хүсэлт, танилцуулга, судалгааг бэлтгэн хүргүүлсэн.

Хан-Уул дүүргийн Хөдөө аж ахуй, аялал жуулчлалын газраас зохион байгуулсан Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийн зөвлөгөөнд оролцож, тариалангийн даатгалын бүтээгдэхүүний талаар танилцуулга тавьж хэлэлцүүлэв.

Дорнод аймгийн Чойбалсан хотод зохион байгуулагдсан Дорнод аймгийн тариаланчдын уулзалтад Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-ийн Бизнес хөгжил, төслийн газрын дарга, Андеррайтингийн газрын андеррайтер, агрономч нар болон тариалангийн даатгалд оролцогч Ард даатгал ХХК-ийн зөвлөх, МИГ даатгал ХХК-ийн газрын дарга нар хамтран оролцлоо. Тус зөвлөгөөнд Дорнод аймгийн Засаг дарга, Хөдөө аж ахуйн газрын төлөөлөл, Мэргэжлийн хяналтын газар, Газрын харилцаа, хот байгуулалтын газар, Ус цаг

уур, орчны шинжилгээний албаны төлөөлөл болон нийт 17 тариалан эрхлэгч аж ахуйн нэгжийн 22 хүн оролцов. Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-ийн зүгээс тариалан эрхлэгч нарт зориулж, тариалангийн эрсдэл, тариалангийн даатгалын бүтээгдэхүүн болон түүний хэрэгжилтийн үр дүнг танилцуулж, тариаланчидтай санал солилцсон.

Нэрлэсэн эрсдэлт улаан буудайн даатгал /НЭУБД/:

“Монголын үр тариа эрхлэгчдийн Газар тариалан холбоо”-ноос 2018 оны 3 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулсан уулзалтад тус компанийн агрономич, газар тариалангийн андеррайтер нар оролцсон.

Төв аймагт 2018 оны 3 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулагдсан “Үр тарианы үйлдвэрлэл эрхлэгчдийн зөвлөлдөх уулзалт”-д оролцож, НЭУБД-ын талаар танилцуулга хийж, тус аймгийн Хөдөө аж ахуйн газрын мэргэжилтнүүд болон тариаланчидтай уулзаж, санал бодлоо солилцсон.

НЭУБД хэрэгжүүлэх хүсэлтээ Ард даатгал ХХК, Бодь даатгал ХХК, МИГ даатгал ХХК, Монре даатгал ХХК-ууд ирүүлсэн бөгөөд эдгээр даатгалын компаниудтай уулзалт зохион байгуулж, тариалангийн даатгалын бүтээгдэхүүн болон тариалангийн даатгалд хэрхэн оролцох талаар мэдээлэл өгч, дээрх компаниудад болон Санхүүгийн зохицуулах хороонд даатгалын бүтээгдэхүүнийг бүртгүүлэх зорилгоор НЭУБД-ын бүтээгдэхүүний холбогдох судалгаа, гэрээ, гарын авлага, заавар, тооцооллыг бэлтгэн хүргүүлсэн.

Ард даатгал ХХК, Бодь даатгал ХХК, МИГ даатгал ХХК-ууд улаан буудайн даатгалын үйл ажиллагааг хамтран хийх зорилготой Хам /хамтарсан гэдэг үгийн товчлол/ даатгалын гэрээ байгуулан 2018 оны НЭУБД-д хамтарч оролцохоор болж Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-тай “Хөдөө аж ахуйн давхар даатгалын хувь оролцооны гэрээ” байгуулсан.

НЭУБД-д оролцогч даатгалын компаниудын холбогдох ажилтнуудад зориулсан НЭУБД-ын андеррайтинг, хохирол үнэлгээ, талбайн үзлэг шалгалт хийх сургалтыг зохион байгууллаа.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас улаан буудайн үр тариалах зөвшөөрөл авсан Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын Товхонхан ХХК, Сэлэнгэ тариа ХХК, Ерөө сумын Их шинэстэй ХХК, Орхонтуул сумын Орхон хөгжил ХХК, Орхон тариа ХХК, Хөвсгөл аймгийн Тариалан сумын Алтандуулга ХХК, Төв аймгийн Жаргалант сумын Алтан залаа ХХК, Эрдэнэсант сумын Буянт төв ХХК, Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Эг тариа ХХК гэсэн нийт 9 аж ахуйн нэгжийн 1505.3 га талбайн үрийн улаан буудайг, Төв аймгийн Эрдэнэсант сумын Сантын тариа ХХК, Угтаал сумын Элсэн цагаан ХХК нийт 1003 га талбайн таваарын улаан буудайн даатгалд хамруулсан. Нийт 11 аж ахуйн нэгжийн үрийн болон таваарын 2508.3 га талбайг улаан буудайн даатгалд хамруулж, даатгалын гэрээг Ард даатгал ХХК, Бодь даатгал ХХК, МИГ даатгал ХХК-ууд дээрх аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан байна. Давхар даатгалын хураамжид 115,667,227.51 /нэг зуун арван таван сая зургаан зуун жаран долоон мянга хоёр зуун хорин долоон төгрөг тавин нэгэн мөнгө/ төгрөгийг төвлөрүүллээ.

НЭУБД-ын үзлэг шалгалт /урьдчилсан ургац тогтоолт. эрсдэлийн дүүдлага/

2018 оны 8 дугаар сарын 28-ны өдрөөс 9 дүгээр сарын 06-ны өдрүүдэд НЭУБД-ын гэрээ байгуулсан 9 аж ахуйн нэгжийн 1505.3 га талбайн үрийн улаан буудайг, 2 аж ахуйн нэгжийн 1003 га талбайн таваарын улаан буудайн урьдчилсан ургац тогтоолтыг хийв. Урьдчилсан ургац тогтоолтоор Төв аймгийн Сантын тариа ХХК болон Буянт төв ХХК-уудын даатгуулсан талбайн улаан буудай мөндөрт цохиулсан байдалтай, Төв аймгийн Алтан залаа ХХК, Сэлэнгэ аймгийн Их шинэстэй ХХК болон Орхон тариа ХХК-уудын даатгуулсан талбайн улаан буудайн болц тааруу, дундаж ургацын хэмжээнд хүрэхгүй

үзүүлэлттэй байсан тул нөхөн төлбөр авч болзошгүй гэж тооцон бодит ургац тогтоохоор шийдвэрлэсэн. Бусад аж ахуйн нэгжийн даатгуулсан талбай нь ургацаа хураан авах хүртэл ямар нэгэн эрсдэлийн тохиолдол гарахгүй бол нөхөн төлбөр авахгүй гэж үзсэн.

НЭУБД-ын бүтээгдэхүүнд даатгуулсан тариалан эрхлэгчдийн даатгуулсан талбайд мөндөр болон цасны эрсдэлээс хохирол үүссэн дуудлагаар очиж үзлэг хийн хохирлыг үнэлж ажиллалаа. Үзлэг шалгалтаар:

- Мөндрийн эрсдэлийн дуудлагаар Элсэн цагаан ХХК, Сантын тариа ХХК болон Буянт төв ХХК-уудад үзлэг хийхэд Сантын тариа ХХК нь 100 хувь, Элсэн цагаан ХХК, Буянт төв ХХК нь тодорхой хэмжээгээр ургац алдсан байсан.
- Цасны эрсдэлийн дуудлагаар Алтан залаа ХХК, Элсэн цагаан ХХК, Орхон хөгжил ХХК, Орхон тариа ХХК болон Их шинэстэй ХХК-уудад үзлэг хийхэд даатгуулагчдын даатгуулсан болон даатгуулаагүй ихэнх талбай цасанд дарагдан ургац газарт бүрэн налж, хураах боломжгүй болсон байлаа. Эдгээр аж ахуй нэгжээс Орхон тариа ХХК-ийн даатгуулсан 62 га талбайд бодит ургац тогтоолт хийх боломжтой бөгөөд бусад даатгуулсан 1126 га талбайнуудад бодит ургац тогтоолт хийх шаардлагагүй, ургац 100 хувь алдсан болохыг тогтоолоо.

Арилжааны банктай хамтын ажиллагааны хүрээнд:

Хаан банкнаас 2018 оны 03 дугаар сарын 21, 28-ны өдөр зохион явуулсан Газар тариалангийн салбарыг дэмжих зорилготой гаргаж буй тариалангийн зээл болон даатгалын бүтээгдэхүүнийг хэрхэн хослуулан хэрэгжүүлэх талаарх уулзалтад оролцож, санал бодлоо солилцлоо.

Хаан банктай газар тариалангийн зээлийг НЭУБД-ын бүтээгдэхүүнтэй хамтран хэрэгжүүлэх, хоорондын мэдээллийн нууцыг хамгаалах зорилгоор “Нууцлалын гэрээ”-г байгуулсан. Мөн Хаан банкнаас даатгуулсан тариаланчдад зээлийн хүүгийн хөнгөлөлт болон зээлийн хэмжээг нь нэмэгдүүлэхээр болсон.

Хаан банкны Жижиг, дунд үйлдвэрлэлийн бизнесийн албаны мэргэжилтэнтэй уулзаж, газар тариалангийн зээл болон улаан буудайн даатгалыг хэрхэн хэрэгжүүлэх, тариалан эрхлэгчдэд ямар шаардлага тавих, зээлийн ямар хөнгөлөлт үзүүлэх талаар харилцан ярилцсан. Уулзалтаар улаан буудайн даатгал хэрэгжүүлэхээр сонгогдсон Дорнод, Дархан-Уул, Хэнтий, Сэлэнгэ, Төв, Булган, Хөвсгөл гэсэн 7 аймгаас даатгах боломжтой аж ахуйн нэгжийн нэрс болон сумын даатгалыг хураамжийн мэдээллийг хүргэсэн.

Голомт болон Төрийн банкны Даатгалын хэлтсийн ажилтан нартай 2018 оны 5 дугаар сарын 16-ны өдөр НЭУБД-ын талаар уулзалт зохион байгуулсан бөгөөд банкнуудын зүгээс НЭУБД-ыг сонирхож байгаагаа илэрхийлж, хамтарч ажиллах талаар судалгаа хийхээр болсон.

Тариалангийн даатгалын эрх зүйн орчныг бүрдүүлэх ажлын хүрээнд:

Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй төсөл”-ийн хүрээнд Тариалангийн даатгалын техник эдийн засгийн үндэслэл, тооцоолол хийх олон улсын зөвлөх гэрээлэн авч ажиллуулах болсны дагуу олон улсын зөвлөх Себастиан Маалер /Гэфауэф Ферзихэрунгс Маклер ХХК/-ын бэлтгэсэн тайлантай танилцаж, онлайн хэлэлцүүлэг хийлээ. Тус хэлэлцүүлгээр тайланд өгсөн саналуудыг ярилцаж, нэмэлт өөрчлөлт оруулахаар болсон. Мөн олон улсын зөвлөх С.Маалерийн боловсруулсан тариалангийн даатгалын тухай хуулийн төсөл, танилцуулгыг уншиж судлав. Зөвлөхийн эхний тайлан болон нэмэлт тайланг нэгтгэн Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй төсөл” болон ХХААХҮЯ-ны холбогдох мэргэжилтэнд хүргүүлээ.

Тус зөвлөх нь 2018 оны 9 дүгээр сарын 03-ны өдрөөс 06-ны өдрүүдэд ХХААХҮЯ-нд болсон Тариалангийн даатгалын хуулийн ажлын хэсгийнхэнтэй хийсэн уулзалт, ХААИС дээр зохион байгуулсан судлаач, эрдэмтэд, багш нарын уулзалт болон Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК дээр болсон Техник, эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/-ийн үр дүнг хэлэлцэх уулзалтуудад оролцож, санал солилцов.

Мөн Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй төсөл”-ийн холбогдох байгууллагуудын төлөөлөгчдөөс бүрдсэн үнэлгээний багтай уулзаж, тариалангийн даатгалын талаар хэрэгжүүлсэн үр дүн, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар харилцан санал солилцлоо. Цаашид тариалангийн даатгалын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох тал дээр хамтарч ажиллахаар боллоо.

2.3. Эрчимжүүлсэн мал аж ахуйн даатгалын бүтээгдэхүүн

Бодь даатгал ХХК-тай хамтран Сэлэнгэ аймгийн Мандал суманд байрлах Макс Агро ХХК-ийн саалийн үнээний фермийн саалийн үнээ, бяруу, тугал зэрэг нийт 439 толгой үхрийг даатгалд хамруулах зорилгоор андеррайтингийн үзлэг шалгалт, бүртгэл хийсэн. Бүртгэлд хамрагдсан 439 үхрээс гэмтэж бэртсэн болон хэт тураалтай 28 үнээг даатгалд хамруулах боломжгүй гэсэн малын эмчийн дүгнэлтээр хасаж үлдсэн үнээ 169, бяруу 114, тугал 128 нийт 411 үхрийг даатгалд хамрууллаа.

СКОР /SCOR/ олон улсын давхар даатгалын компаниас ирсэн эрсдэлүүдийн даатгалын хураамжийн хувийг үндэслэн эрчимжүүлсэн даатгалын хураамжийн хувийг 4.05 хувь болгон Бодь даатгал ХХК-тай хувь тэнцүүлсэн давхар даатгалын гэрээ буюу 50:50 хувиар хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж, хураамжийн орлого болох 31,438,125.00 /гучин нэгэн сая дөрвөн зуун гучин найман мянга нэг зуун хорин таван/ төгрөг төвлөрүүлсэн.

Макс Агро ХХК-ийн үнээ, бяруу, тугалууд даатгалд хамрагдаж хагас жил болох хугацаанд нийт 31 тохиолдол гарснаас халтирч унасан эрсдэл 16, хоол тэжээлээс үүдэлтэй 11, нүхэнд унаж үхсэн 1, уушгины өвчлөл 1, зүрхний цоорол 1, төрхийн хүндрэлээс үүдэлтэй өвчлөл 1 байлаа. Эрсдэл бүр дээр очиж андеррайтингийн үзлэг шалгалт хийж, ферм доторх цэвэрлэгээ, арчилгаа маллагаа зэрэгт хяналт тавин ажиллалаа. Шалгалт үзлэг бүрийг дүрс бичлэг хийн, лабораторийн шинжилгээнд үндэслэн баталгаажууллаа.

2.4. Актуар тайлан, тооцоолол, судалгаа

Нөөц сангийн тооцооллын үр дүнг Санхүүгийн зохицуулах хороонд танилцуулах ажлын хүрээнд:

Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан “Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох, актуарын стандарт, үнэлгээ болон актуарчийн хяналт, шалгалт хийх, тайлан гаргах журам”-ын 3.1-д заасны дагуу 2018 оны 3 дугаар улирлын байдлаар малын индексжүүлсэн даатгал, нэрлэсэн эрсдэлт улаан буудайн даатгал, газар тариалангийн хүнд машин, механизмын даатгал, эрчимжүүлсэн мал аж ахуйн даатгалын нөөц сангийн тооцоолол болон үр дүнг танилцуулсан актуарын тайланг бэлтгэж, цаг хугацаанд нь Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлсэн.

Давхар даатгаагчийн төлбөрийн чадварыг тооцоолох ажлын хүрээнд:

Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 360 дугаар тогтоолоор батлагдсан “Давхар даатгаагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын дагуу төлбөрийн чадварын харьцааг 2018 оны 3 дугаар улирлын байдлаар тооцоолж холбогдох хавсралтуудыг бэлтгэсэн. Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-ийн 2018 оны 3 дугаар улирлын байдлаар төлбөрийн чадварын

зохистой харьцаа нь 183.89 хувьтай байгаа нь дээрх журмын 2.4-т “Давхар даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцаа нь 100 хувь буюу түүнээс илүү байвал зохино” гэж заасан шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллалаа.

НЭУБД-ын хураамжийн хувийг шинэчлэх ажлын хүрээнд:

НЭУБД-ын бүтээгдэхүүний 2018 оны борлуулалттай холбогдуулан Сэлэнгэ, Булган, Дархан-Уул, Төв, Дорнод, Өвөрхангай, Хэнтий, Хөвсгөл аймгуудын нийт 100 гаруй сум болон 1120 гаруй аж ахуйн нэгжүүдийн 2017 оны улаан буудайн тариалсан талбай, хураан авсан нийт ургацын дүн мэдээг эмхэтгэлээ. Уг дүн мэдээнд үндэслэн хураамжийн хувийг сум тус бүрээр шинэчлэн тооцоолсон. 2017 оны гангийн улмаас үүдэн ургац алдсантай холбоотой дээрх 8 аймгийн дундаж хураамжийн хувь өссөн байна.

НЭУБД-ын 2018 оны борлуулалтын улиралд даатгуулах хүсэлт өгсөн Газар өгөөж ХХК, Их шинэстэй ХХК, Товхонхан ХХК, Орхон хөгжил ХХК-ийн талбайд даатгалын компанийн гэрээт агрономич Х.Мөнхтуяа андеррайтингийн үзлэг хийж, хяналт шалгалтын тайланг англи хэл рүү орчуулж бэлтгэн, СКОР /SCOR/ олон улсын давхар даатгалын компани руу явуулсан.

НЭУБД-ын хураамж тооцооллын танилцуулга болон тооцооллын эксэл файлыг англи хэл рүү орчуулан, Ханновер Ре /Hannover Re/ олон улсын давхар даатгалын компани руу явуулсан.

Индексжүүлсэн улаан буудайн даатгалын бүтээгдэхүүн боловсруулах төслийн хүрээнд хамтран ажиллагч байгууллага СКОР /SCOR/ болон Зэдэкс /ZedX/ олон улсын давхар даатгалын компанийн мэргэжилтнүүдтэй цахим уулзалт хийсэн бөгөөд уулзалтаар газар тариалангийн бүс нутгийг нарийвчлан тэмдэглэсэн газрын зургийг СКОР /SCOR/ олон улсын давхар даатгалын компанийн мэргэжилтэн Доуч Хэнри /Douche Henri/-д цахим шуудангаар хүргүүлэв.

НЭУБД-ын хохирлын харьцааг боломжит мэдээнд тулгуурлан тооцоолохдоо улсын түвшинд, даатгалд хамрагдсан сумын түвшинд болон даатгалд хамрагдсан аж ахуйн нэгжийн түвшинд тус тус тооцоолов.

НЭУБД-д 2018 онд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн хувьд даатгалын нөөц санг хэрхэн бүрдүүлэх талаар зөвлөмжийг бэлтгэсэн.

Газар тариалангийн хүнд машин, механизмын даатгал /ГТХММД/-ын бүтээгдэхүүнтэй холбогдох актуар тооцоолол хийн, тайлан бэлтгэх:

Санхүүгийн зохицуулах хорооноос бэлтгэн гаргадаг “Даатгалын салбарын санхүүгийн үйл ажиллагааны нэгдсэн тайлан”-д тусгагдсан хөрөнгийн даатгалын зах зээлийн нийт үнэлгээ, нийт хураамж болон нөхөн төлбөрийн 2011 оноос 2017 оны тоон мэдээллийг улирал тус бүрээр цуглуулан эмхэтгэсэн.

ГТХММД-ын хураамж болон нөөц сангийн тооцооллыг дээрх мэдээнд үндэслэн тооцоолж, тооцооллын актуар тайланг Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн 9/2599 тоот тайлангийн хариуд бүтээгдэхүүнийг Хороонд бүртгүүлэх шаардлагын дагуу бэлтгэн хүргүүлсэн.

ГТХММД-ын 3 төрлийн багц /1.Хөдөө аж ахуйн машин механизм, 2.Хөдөө аж ахуйн чиргүүл, дүүжин машин, 3.Үтрэм/будааны агуулах ачих дамжуулах тоног төхөөрөмж/ тус бүрийн хураамжийн үнэлгээг жигнэсэн дундаж аргаар нийт хураамжийн хувийг 0.3 хувь байхаар тооцоолсон бөгөөд тооцоолоход эрсдэлийн түвшнээсээ хамаарч 0.5:0.35:0.15 харьцаатайгаар 0.35 хувь, 0.24 хувь, болон 0.1 хувь гарсан.

Сибэлиүс /SIBELIUs/ төсөлд шаардагдах мэдээллийг бэлдэж өгөх:

Их Британи Улсын Засгийн газрын бүрэлдэхүүн хэсэг болох Английн Сансарын агентлагаас санхүүжилттэй Сибэлиүс /SIBELIUs/ төсөл хөтөлбөр нь хиймэл дагуулаас авсан цаг агаарын мэдээг малын даатгалд ашиглах, цаг агаарт суурилсан малын даатгалыг боловсруулж, малчдыг санхүүгийн эрсдэлээс хамгаалан амьжиргааг сайжруулах зорилготой юм.

Төсөл нь Хэнтий аймгийн Дэлгэрхаан сум, Жаргалхаан сум, Булган аймгийн Хишиг-Өндөр сум, Могод сум, Дорноговь аймгийн Айраг сум, Алтанширээт сум гэсэн 6 туршилтын бүсүүдэд хэчнээн хүний амьжиргаа МИД-ын хүрээнд хамгаалагдаж байгааг тодорхойлох хүсэлтийн дагуу 2017 оны даатгуулагч малчны тоо болон нийт хүн ам, өрхийн тоог Үндэсний статистикийн хорооноос мэдээллийг авч бэлтгэн, мөн Баянхонгор аймгийн Айраг сумын засаг дарга болон малчдын төлөөлөгчидтэй хийсэн уулзалтын үр дүнг дүгнэсэн тайлантай танилцаж Айраг сумд нөхөн төлбөр олгосон байдал, МИД-ын нөхөн төлбөр олгох процессын талаар мэдээг төслийн мэргэжилтэн Ник Вокэр /Nick Walker/-т хүргүүлсэн.

Сибэлиүс /SIBELIUs/ төсөл хөтөлбөрийн хүрээнд Монголд ирсэн Олон улсын зөвлөх, даатгалын ахлах мэргэжилтэн Мослех Ахмед /Mosleh Ahmed/-тай оролцогч 9 даатгалын компани болон зуучлагч 2 банктай уулзах уулзалтыг зохион байгуулж, оролцсон бөгөөд газар тариалан эрхлэгч болон малчдаас авах судалгааны төслийг бэлтгэсэн.

Мөн тус төслийн 2017 оны хиймэл дагуулын мэдээлэл дээр үндэслэн бэлтгэсэн улаан буудай тариалсан талбайн зурагтай танилцаж, зургийн үнэн зөв байдлыг шалгах хүсэлтийн дагуу компанийн актуарч, агрономич нар шалгаж, хариу тайлбар бэлтгэж, 2017 оны тухайн талбайд хийгдсэн хохирол үнэлгээний тайлангуудын хамт төслийн мэргэжилтэн Ник Вокэр /Nick Walker/-т хүргүүлэв.

2.5. Олон улсын давхар даатгал

МИД-ын дээд болон дунд түвшний эрсдэлийн зарим хэсгийг олон улсын давхар даатгалд хамруулах хэмжээг 2018 оны бизнес төлөвлөгөө болон Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-ийн нөөц сангийн үлдэгдэлд үндэслэн тооцоолсон албан захиаг тус бүрээр боловсруулж олон улсын даатгагч нарт хүргүүлсэн бөгөөд давхар даатгагч нараас ирүүлсэн үнийн саналтай танилцан 2018 оны эрсдэлийн дээд болон дунд түвшний давхар даатгалын гэрээг байгуулаад байна.

- Эрсдэлийн дээд түвшин: МИД-ын дээд түвшинд ирүүлсэн давхар даатгалын үнийн саналуудаас хамгийн бага үнийн санал ирүүлсэн Ханновер Ре /Hannover Re/ олон улсын давхар даатгалын компанитай нийт сонгосон үнэлгээний 0.3 хувь давсан 2.9 хувь хүртэлх эрсдэлийг давхар даатгах гэрээг байгууллаа.
- Эрсдэлийн дунд түвшин: Олон улсын давхар даатгагч нараас ирүүлсэн үнийн саналуудаас хамгийн бага үнийн санал ирүүлсэн болон Газар тариалангийн индексжүүлсэн даатгалын бүтээгдэхүүний загварчлал боловсруулахад хамтран ажиллахаар болсон СКОР /SCOR/ олон улсын давхар даатгалын компанийг сонгон 2018 оны МИД-ын дунд түвшний давхар даатгалын гэрээ байгуулсан. Мөн түүнчлэн 2018 оны эрсдэлийн дунд түвшний эрсдэл даах чадварт үндэслэн нийт хураамжийн 65 хувь давсан 125 хувь хүртэлх эрсдэлийн хэмжээгээр давхар даатгалын гэрээ байгуулан ажиллалаа.

СКОР /SCOR/ олон улсын давхар даатгалын компанитай байгуулах Хөдөө аж ахуйн давхар даатгалын хувь оролцооны гэрээний төсөл болон 2018 онд даатгуулсан аж ахуйн нэгжүүдийн мэдээлэл /даатгуулсан талбай, хураамж, даатгуулсан талбайн координат гэх мэт/-ийг бэлтгэн хүргүүлээ.

Нэрлэсэн эрсдэлт улаан буудайн даатгалын бүтээгдэхүүний нийт эрсдэлийн 75 хувийг давхар даатгах саналыг СКОР /SCOR/, Ханновер Ре /Hannover Re/ болон Партнер Ре /Partner Re/ гэсэн олон улсын давхар даатгагчид руу явуулсан. Давхар даатгач нарын зүгээс СКОР /SCOR/-ийн зүгээс нийт эрсдэлийн 75 хувийг давхар даатгах гэрээг Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-тай байгуулсан.

Үндэсний давхар даатгалын тогтолцоог байгуулах ажлын хүрээнд дотоодын даатгалын компаниуд болон олон улсын давхар даатгач нартай хөдөө аж ахуйн давхар даатгалаас бусад чиглэлээр хамтран ажиллах талаар уулзаж ажилласан. Уулзалтын дүнд хөдөө аж ахуйн давхар даатгалын хүрээнд хамтран ажиллаж ирсэн СКОР /SCOR/, Ханновер Ре /Hannover/ болон Свисс Ре /SwissRe/, Рашшиан Ре /RussianRe/ гэсэн олон улсын давхар даатгалын компаниудтай хамтран ажиллахаар болсон.

ГУРАВ. ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА ХИЙЖ, ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ ГАРГАЖ ТУРШИХ АЖЛЫН ХҮРЭЭНД:

3.1. Хөдөө аж ахуйн бусад салбарт шаардлагатай байгаа даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд үр дүнтэй нэвтрүүлэх

Газар тариалангийн хүнд машин, механизмын даатгал:

Тариалан эрхлэгчдийг дэмжих сан, Ди Би Эм лизинг ХХК болон Агротрак ХХК-тай хамтран 2018 оны 01 дүгээр сарын 22-ний өдрөөс 26-ны өдрүүдэд тариалан эрхлэгч нарт Вектор-410 серийн комбайны ашиглалтын талаар сургалт хийсэн ба уг сургалтын үеэр Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК болон Ард даатгал ХХК, Монгол даатгал ХХК-ийн мэргэжилтнүүд даатгал, даатгалын эрсдэлийн тухай сургалт хийж, тариалан эрхлэгч нартай даатгалын гэрээ байгуулан ажиллалаа. Уг сургалтад нийт 40 орчим тариалан эрхлэгч нар оролцсон бөгөөд хүнд машин, механизмын даатгал, эрсдэлээс сэргийлэх тухай зөвлөмж өгч ажиллав.

ХХААХҮЯ-ны “Тариалан эрхлэлтийг дэмжих сан”-аас газар тариалангийн техникүүдийг шинэчлэл хийгдэж буй ажлын хүрээнд импортоор ирсэн техникүүдийг давхар даатгах зорилгоор Монгол Улсын Хөгжлийн банкны охин компани болох Ди Би Эм лизинг ХХК /ХХААХҮЯ-ны “Тариалан эрхлэлтийг дэмжих сан”-гаар дамжуулан түрээслэгчээр ажиллаж байгаа/-тай хамтран ажиллах гэрээ байгууллаа.

Ди Би Эм лизинг ХХК-ийн Газар тариалангийн хүнд машин, механизмын тоног төхөөрөмжийг даатгуулах хүсэлтэд 2017 онд Ард даатгал ХХК, Монгол даатгал ХХК сонгогдон давхар даатгалын гэрээ байгуулсан бөгөөд нийт 64 аж ахуй нэгж, иргэн даатгуулан, нийт давхар даатгалын хураамжид 9,354,875.85 /есөн сая гурван зуун тавин дөрвөн мянга найман зуун далан таван төгрөг наян таван мөнгө/ төгрөг төвлөрүүлсэн.

ОХУ-аас орж ирсэн тоног төхөөрөмжийг Ди Би Эм лизинг ХХК-ийн даатгуулах хүсэлтэд Ард даатгал ХХК, МИГ даатгал ХХК сонгогдон 2018 оны 3 дугаар улиралд давхар даатгалын гэрээ байгуулсан. Нийт 56 аж ахуйн нэгж, иргэн даатгуулж 14,497,457.80 /арван дөрвөн сая дөрвөн зуун ерэн долоон мянга дөрвөн зуун тавин долоон төгрөг наян мөнгө/ төгрөгийн хураамж төвлөрүүлсэн.

Гахайн аж ахуйн болон шувууны аж ахуйн даатгал:

Түмэн шувуут ХХК-ийн 300,000 өндөглөгч тахиаг, нэгж тахиа 10,000 төгрөгөөр үнэлж, даатгалын хураамжийн хувь 2.5 хувиар тооцоолж нийт 3.0 сая төгрөгийн үнэлгээтэй даатгалын гэрээний төсөл дээр ажиллан санал хүргүүлэв. Ард даатгал ХХК, Түмэн шувуут ХХК компаниудын хамтран ажиллах саналыг боловсруулан дахин уулзахаар тохирсон.

БНЭУ, ОХУ, АНУ зэрэг улсын шувууны аж ахуйн давхар даатгалын туршлагыг судалж, “Эрчимжүүлсэн фермийн даатгал”, “Тахианы фермийн даатгал” сэдэвтэй танилцуулга, судалгааны мэдээллийг боловсруулан удирдлагад танилцуулж, компанийн ажилтнуудад мэдээлэл хүргэх зорилгоор дотоод сургалт хийлээ.

ОХУ-ын Альфастрахование даатгалын компанийн гахайн аж ахуйн даатгалын бүтээгдэхүүнийг судалж, даатгалын гэрээг орчуулав. Бусад даатгалын компаниудын эрчимжүүлсэн мал аж ахуйн даатгалын бүтээгдэхүүнийг судалж, эрсдэлийн шинжилгээ хийсэн.

Гахай болон шувууны аж ахуйн даатгалын хэрэгжүүлж буй олон улсын туршлагыг /БНЭУ, ОХУ, АНУ, БНКаЗУ/ судлан, гахайн аж ахуйн даатгалын танилцуулга, даатгалын жишиг гэрээ, даатгалын өргөдөл, тодорхойлолтыг боловсруулав.

Засгийн газраас баталсан гахай, шувууны аж ахуйд мөрдөгдөх журам, мал амьтны гоц халдварт өвчин болон бусад өвчний жагсаалтыг судлан, эрсдэлүүдийг судлав.

Ард даатгал ХХК-ийн зүгээс тахиан фермерийн даатгалд хамтран ажиллах санал тавьж, даатгалын гэрээ, эрсдэлийг судлан уулзалт хийж, санал өгч ажилласан.

Банкны сувгаар дамжуулан борлуулах шинэ даатгалын бүтээгдэхүүний зах зээлийн судалгаа:

Банкны сувгаар дамжуулан борлуулах шинэ даатгалын бүтээгдэхүүний зах зээлийн судалгаа хийх ажлын хүрээнд газар тариалан, экспорт, эрчимжүүлсэн мал аж ахуй болон бусад орон нутгийн иргэдийн хэрэгцээнд нийцсэн шинэ даатгалын бүтээгдэхүүнийг арилжааны банкнуудтай хамтран гаргах боломжийн талаар судалж байна. Банкнаас гаргаж байгаа зээлийн бүтээгдэхүүнийг хэрхэн даатгалын бүтээгдэхүүнтэй үр ашигтай хамтран гаргаж болох талаар банкнуудтай харилцан санал солилцлоо. Тухайлбал, Хаан банкны жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн хэлтсийн мэргэжилтнүүдтэй уулзаж, 2019 онд хэрхэн хамтран ажиллах талаар санал солилцов.

Хаан банкны зүгээс 2019 онд экспортлогчдыг дэмжиж ажиллах зорилго тавьсан ба экспортлогчдод бага хүүтэй зээлийн бүтээгдэхүүн гаргаж нэвтрүүлэхээр ажиллаж байгаа тул уг зээл дээр манай компанитай хамтран ажиллах, эргэлтийн хөрөнгийн даатгал, экспортын даатгалыг хэрэгжүүлэх, мөн бусад төслүүд дээр хамтран ажиллаж, даатгалын бүтээгдэхүүнийг нэвтрүүлэхээр зорьж байна. Бидний зүгээс Хаан банкны хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийн талаар мэдээлэл авч, түүнд тохирох даатгалын бүтээгдэхүүн санал болгохоор тохиролцлоо.

Шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэхэд шаардлагатай холбогдох судалгаа шинжилгээ:

Монгол Улсын Хөгжлийн банкны төлөөлөлтэй Бизнес хөгжил, төслийн газрын дарга, ажилтнууд уулзалт хийв. Уулзалтаар Засгийн газрын 2018 оны 47 дугаар тогтоолоор батлагдсан “Ноолуур” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ноолуурын үйлдвэрлэл эрхлэгчдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох болсонтой холбогдуулан экспортыг нэмэгдүүлэхэд дэмжлэг болох үүднээс Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-ийг эргэлтийн хөрөнгийн даатгалд ноолуурын үйлдвэрлэл эрхлэгчдийг хамруулж зээлийн хэмжээг нэмэгдүүлэн ажиллах боломжийн талаар ярилцсан. Эргэлтийн хөрөнгийн даатгалын ерөнхий нөхцөл, танилцуулгыг Хөгжлийн банканд өгч, хамтран ажиллахаар санал солилцлоо.

“Ноолуур” хөтөлбөрийн хүрээнд 400.0 орчим тэрбум төгрөгийг ноолуурын үйлдвэрлэл эрхлэгч нарт хөнгөлөлттэй нөхцөлөөр зээлдүүлэх бөгөөд манай компани хөнгөлөлттэй зээл авахад барьцаа хөрөнгө дутсан компаниудыг даатган ажиллах юм.

Санхүүгийн зохицуулах хорооны даатгалын салбарын тайланд тусгагдсанаар хариуцлагын даатгалд жилдээ 7.0 тэрбум гаруй төгрөгийн хураамж төвлөрүүлдэг ба үүний 4.0 тэрбум орчим төгрөгийг олон улсын давхар даатгагч руу шилжүүлж, эргэн 20.0 сая төгрөгийн нөхөн төлбөрийг авдаг тоон мэдээлэл байна.

Сайн дурын даатгалын шинэ хэлбэрүүд болох ачааны, хариуцлагын, гэнэтийн ослын, хөрөнгийн, санхүүгийн, зээлийн даатгалын хэлбэрээр даатгалын ерөнхий нөхцөл, эрсдэл, үнэлгээ, хураамж болон зах зээлийн тойм судалгааг хийж, журам болон баталгааны маягтыг боловсруулан 2019 онд даатгал хийхээр төлөвлөөд байна.

Хариуцлагын даатгалын судалгааг эхний ээлжид хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүнтэй холбоотой гарсан санал гомдол, бусдын эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан хохирлын талаар судалгаа хийсэн ба Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын гаргасан тайлангаас мэдээлэл цуглуулав. Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэр, үйлчилгээний хяналтын чиглэлээр их эрсдэлтэй үнэлэгдсэн улсын хэмжээнд нийт 2112 объектод шалгалт хийхэд хүнсний худалдаа, үйлдвэр, үйлчилгээний хяналтын чиглэлээр шалгалтад хамрагдсан объектын 22.4 хувь нь их, 54.7 хувь нь дунд, 22.3 хувь бага эрсдэлтэй, хөдөө аж ахуйн хяналтын чиглэлээр шалгалтад хамрагдсан объектын 14 хувь нь их, 46.3 хувь нь дунд, 34.6 хувь бага эрсдэлтэй тус тус шалгагдсан байна гэж уг тайланд тусгагджээ.

Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн тал гаруй хувь нь дундаас дээш эрсдэлтэй байгаа нь иргэдийн эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгөд хохирол учруулах эрсдэлтэй тул даатгалын үйлчилгээ үзүүлж ажиллах боломжтой юм. Уг судалгааг цаашид үргэлжлүүлэн, сүүлийн 5 жилийн тоон мэдээг нэгтгэн статистик мэдээ бэлтгэн холбогдох судалгааг гаргасан.

Гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор газар хөдлөлтийн параметрийн даатгалын бүтээгдэхүүн боловсруулах судалгааны ажлын хүрээнд Швейцарын Холбооны Улсын Целсиус-Про /Celcius Pro/, олон улсын давхар даатгалын Свисс Ре /Swiss Re/ зэрэг компаниудтай хамтран ажиллаж, цахим уулзалтуудыг хийж, уг бүтээгдэхүүний талаар судалгаа шинжилгээ боловсруулж, олон улсын хамтран ажиллагч давхар даатгалын компаниудын үнийн санал, бүтээгдэхүүний танилцуулга, газар хөдлөлтийн зураглалын шинж тэмдгүүд, гарын авлага зэрэг бичиг баримтуудыг орчуулсан.

Хаан болон Төрийн банк, Бодь даатгал ХХК, Монгол даатгал ХХК, Практикал даатгал ХХК, МИГ даатгал ХХК-уудын менежерүүдэд газар хөдлөлтийн параметрийн даатгалын талаар танилцуулгыг 2018 оны 11 дүгээр сард хийж, Монгол Улсад уг даатгалыг хэрэгжүүлэх боломжийн талаар ярилцсан. Даатгалын компаниудын зүгээс уг даатгалыг нэвтрүүлэхэд хамтран ажиллахаа мэдэгдсэн ба бүтээгдэхүүн хөгжүүлэлт дээр зарим саналуудыг өглөө. Үүнд: Хураамжийн хувийг багасгах, иргэдэд их ачаалал өгөхөөргүй байх, босго баллын хэмжээг бууруулах талаар санал болгосон. Монгол Улсын газар хөдлөлтийн идэвхтэй бүсийг газрын зураг дээр тодорхой танилцуулбал орон нутаг дахь орон сууцны зээлтэй уялдуулж болох талаар ярилцав. Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн эрсдэлийн удирдлагын газрын дарга Д.Баасансүрэн болон холбогдох мэргэжилтнүүдтэй уулзаж, санал солилцлоо. Онцгой байдлын ерөнхий газрын зүгээс шаардлагатай судалгаа мэдээллийг хуваалцах, уг бүтээгдэхүүнийг нэвтрүүлэхэд дэмжиж хамтран ажиллахаа мэдэгдэв.

Швейцарийн Целсиус Про /Celcius Pro/ компанийн гүйцэтгэх захирал Марк Рувеегд шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэхэд зах зээлийн эрэлт хэрэгцээг тодорхойлох, холбогдох газруудтай уулзалт зохион байгуулах зорилгоор Монгол Улсад айлчлах хөтөлбөрийг боловсруулж, урилга илгээсэн.

Целсиус Про компанийн гүйцэтгэх захирал Марк Рыеегийн хамт 2018 оны 12 дугаар сарын 17-ны өдрөөс 19-ний өдрүүдэд Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Т.Бадрал болон холбогдох удирдлагууд, Монголын ипотекийн корпорац, арилжааны банкнуудын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, газар хөдлөлтийн параметрийн даатгалын бүтээгдэхүүнийг танилцуулж, тэдгээрийн саналыг авч, уг бүтээгдэхүүнийг нэвтрүүлэхэд дэмжиж буйгаа илэрхийлж, хамтран ажиллахаар тохиролцов.

Говь ХК-ийн зүгээс төлбөр тасалдлын даатгал хийлгэх санал тавьсан бөгөөд анхлан даатгагчаар Тэнгэр даатгал ХХК, МИГ даатгал ХХК, Бодь даатгал ХХК хам даатгалын гэрээ хийж оролцохоор болсон. Тэнгэр даатгал ХХК-аас хүргүүлсэн төлбөр тасалдлын даатгалын гэрээг хянаж үзээд зарим заалтыг нэмж, даатгалын хураамжийг тооцоолон 1.275% байхаар санал хүргүүлсэн. Говь ХК-ийн үл хөдлөх хөрөнгө, бараа материал болон тоног төхөөрөмжийн даатгалыг Тэнгэр даатгал ХХК, Миг даатгал ХХК, Бодь даатгал ХХК болон Мандал даатгал ХХК нар хам даатгал хэлбэрээр нийт 17 даатгалын гэрээ бүхий нийт 250 гаруй тэрбум төгрөгийн үнэлгээтэй даатгалд дотоодын давхар даатгагчаар оролцохоор хам даатгалын гэрээг 2018 оны 12 дугаар сарын 17-ны өдөр байгуулав.

Бодь даатгал ХХК-ийн Даатгалын газрын захирал Б.Хүдэртулга, галын эрсдэлийн экспертийн хамт 2018 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр Говь үйлдвэрийн 1 ба 2 дугаар барилга, төв үйлдвэрийн дэлгүүрийн галын аюулгүй байдалтай танилцаж, 2017 онд Говь ХК-ийн дээвэрт галын эрсдэл учирсантай холбогдуулан уг компанийн зүгээс хийсэн галын эрсдэлийн сайжруулалт хэрхэн хийгдсэн талаар хяналт шалгалт хийсэн. Говь ХК-д галын эрсдэл тохиолдсоноос хойш нийтдээ давхардсан тоогоор 22 гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулж, 2.3 тэрбумын засвар хийгдсэн. Мөн олон улсын эрсдэлийн удирдлага, менежментийн аудитын үйлчилгээ үзүүлдэг Макларенс /McLagens/ компанийн 2018 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн Говь ХК-нд хийсэн эрсдэлийн судалгааны тайлантай танилцав.

Говь ХК-ийн нийт даатгалын гэрээнд Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-ийн зүгээс хүлээн авах эрсдэлийн хэмжээг шийдвэрлэхээр 2018 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн “Эрсдэлийн хороо”-ны хурлаар танилцуулав. Уг хурлын шийдвэрээр манай компани нь нийт 15.0 сая ам.доллартой дүйцэхүйц эрсдэлийг хүлээн авахаар шийдвэрлэгдсэн.

Шинэ бүтээгдэхүүнийг нэвтрүүлэхэд зах зээлд оролцогчдын эрсдэлийг тодорхойлж, барьцаа хөрөнгө, зээлийн хүү болон зээлийн эрсдэл ханшийн хэлбэлзэл, төлбөрийн чадварын эрсдэл болон улс төрийн эрсдэл болон Монголбанкны дагаж мөрддөг хууль журмуудыг судлав. Макро эдийн засаг, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн статистик, гадаад худалдааны статистикийн судалгааг гаргав.

Олон улсын давхар даатгагчидтай хамтын ажиллагаа:

Олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор гадаадын давхар даатгалын болон экспортын зээлийн даатгалын компаниудтай холбоо тогтоож ажиллаж байна. Үүнд:

- ОХУ-ын Үндэсний давхар даатгалын компани “РНПК”-тай хамтын ажиллагаа тогтоох албан захидлыг илгээсэн ба Оросын талаас бидний хүсэлтийг хүлээн авч, давхар даатгалын салбарт харилцан ашигтай хамтран ажиллах, хамтын ажиллагааг бэхжүүлэх саналаа ирүүлсэн. 2018 оны 9 дүгээр сарын 20-21 өдрүүдэд Москва хотод зохион байгуулагдах “Үндэсний давхар даатгагчид- Глобал хамтын ажиллагаа” саммит уулзалтад оролцохыг урьсан юм. Тус арга хэмжээнд оролцох төсвийг тооцоолон

гаргаж удирдлагад танилцуулсан боловч цаг хугацааны тохиромжгүй байдлаас болон оролцох боломжгүй болсон.

- Бүгд Найрамдах Филиппин Улсын үндэсний давхар даатгалын корпорац Филна Ре /PhilNaRe/-тэй Монгол Улсын өргөмжит консулаар дамжуулан харилцаа тогтоов.
- ОХУ-ын давхар даатгал даатгалын компани болох Рашшинре /RussianRE/-ийн төлөөлөгчтэй уулзалт хийж цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцлоо. Тус компанийн Бүс нутгийн хөгжлийн газрын захирал В.Борисюктай 2018 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр уулзаж, давхар даатгалын салбар дахь хамтын ажиллагааг улам хөгжүүлэх, туршлага судлан, мэдээлэл солилцон ажилласан.
- 2018 оны 12 дугаар сарын 11-ний өдөр олон улсын давхар даатгалын зуучлагч Юлессе Ре /Ulysse Re/ компанитай уулзаж, давхар даатгалын үйл ажиллагаагаа өргөжүүлэн хамтран ажиллах талаар санал солилцов.
- Беларус Улсын экспортын даатгалын компани Белэксимгарантаас ирүүлсэн давхар даатгалын гэрээг орчуулан, холбогдох удирдлагуудаар хянуулан, нэмэлт санал байхгүй талаар Белэксимгарантад мэдэгдэв. Беларусийн экспортын даатгалын компани Белэксимгаранттай хамтран ажиллаж, автомашины үйлдвэр “МАЗ” компаниас Монгол Улсад автобус хөнгөлөлттэй зээлээр нийлүүлэх хэлцэлд оролцож, давхар даатгалын гэрээ байгуулахаар тохиролцов.
- Швейцарын олон улсын давхар даатгалын Свисс Ре /Swiss Re/ компанитай цахим уулзалтууд зохион байгуулж, газар хөдлөлтийн параметрийн давхар даатгалын саналыг авч ажиллав.
- БНЭУ-ын Үндэсний давхар даатгалын компани руу /GIC RE/ давхар даатгалын салбарт туршлага хуваалцах хамтран ажиллах тухай санал илгээв.

Санхүүгийн Зохицуулах хороо, Сангийн яамны хамтарсан “Санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх” хөтөлбөрийн “Даатгалын салбарын эрсдэлийн удирдлага” төслийн төслийн хүрээнд давхар даатгалын тогтолцоог хөгжүүлэх талаар бичсэн Азийн хөгжлийн банкны зөвлөх Стефен Росситерын тайланг уншиж танилцан, уг зөвлөхтэй холбоо тогтоож Монголд дахин айлчлах хугацаанд уулзалт хийх талаар цахим шуудангаар санал солилцов.

3.2. Үндэсний давхар даатгалын тогтолцоог нэвтрүүлэх

Үндэсний давхар даатгалын компани болох бэлтгэл ажлын хүрээнд

Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн мэргэжилтэн Н.Дэлгэрбат болон бусад мэргэжилтнүүдтэй удаа дараа уулзалт хийж, Үндэсний давхар даатгалын компани /ҮДДК/ байгуулах ач холбогдол, хууль эрх зүйн орчин болон цаашид хэрэгжүүлэх ажлын талаар мэдээлэл өгсөн. Уг уулзалтуудаар Үндэсний давхар даатгалын компани /ҮДДК/ байгуулах эрх зүйн орчныг “Даатгалын тухай хууль”-д зааж өгч, “Даатгалын тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсэгт компанийн төлөөллийг орж ажиллуулах, мөн Экспортын даатгалыг хэрхэн хэрэгжүүлэх талаар мэдээлэл өгч ажилласан. Үүний үр дүнд манай компанийн Ерөнхий хуульч, болон Бизнес хөгжил, төслийн газрын дарга нар хуулийн хэсэгт орон ажиллаж байна.

Үндэсний давхар даатгалын компани болох бэлтгэл ажлын хүрээнд үндэсний давхар даатгалын тогтолцооны хэрэгцээ, шаардлага, үр ашгийг олон нийтэд таниулан сурталчлах зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд гүйцэтгэх захирал ярилцлага өгч, “Засгийн газрын мэдээ” сонин, www.news.mn, www.unep.mn, www.medee.mn сайтуудад тус тус нийтлүүлэв.

Компанийн нэр солихтой холбогдуулан Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт хүсэлт гарган, “Үндэсний давхар даатгал” нэрийг холбогдох журмын дагуу бүртгүүлж хадгалуулсан.

Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг өргөжүүлж, оноосон нэрийг Үндэсний давхар даатгал ХК-ийн компани болгон өөрчлөх тухай, Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулга, судалгааны материал, холбогдох баримт бичгүүдийн хамт Монгол Улсын Сангийн сайдад хүргүүлээ.

Сангийн яамны зүгээс Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-ийн нэрийг өөрчлөх тухай асуудлыг Засгийн газрын хуралдаанд оруулахаар бүх яамдаас санал авсан ба яамдаас ирүүлсэн саналд хариу судалгаа тооцооллыг бэлтгэн хүргүүлэв.

Холбогдох яамдаас санал авч дууссаны дараа Засгийн 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар компанийн нэрийг өөрчлөх асуудлыг оруулж хэлэлцүүлэн, Засгийн газрын 303 дугаар тогтоолоор шийдвэрлүүлсэн. Уг тогтоол батлагдсантай холбогдуулан компанийн дүрмийг шинэчлэн, нэмэлт өөрчлөлт оруулах төслийг боловсруулан бэлтгэж, Сангийн сайдын 2018 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 252 дугаар тушаалаар батлуулсан.

Үндэсний давхар даатгал ХК болж үйл ажиллагаагаа өргөжүүлэх бэлтгэл ажил болгон СЗХ-оос даатгалын хэлбэрээр давхар даатгал хийх тусгай зөвшөөрөл авахаар судалгаа, тооцоолол бүрдүүлэн ажиллалаа. Сайн дурын даатгалын шинэ хэлбэрүүд болох ачааны, хариуцлагын, гэнэтийн ослын, хөрөнгийн, санхүүгийн, зээлийн даатгалын хэлбэрээр зөвшөөрөл авахаар материал бэлдсэнээс хариуцлагын, санхүүгийн, зээлийн гэсэн 3 даатгалын хэлбэрээр судалгаа хийж материал бүрдүүлэн ажиллав.

3.3. Компанийн үйл ажиллагаа болон давхар даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд сурталчлан таниулах

Компанийн ютүб /youtube/ сувгийг /haadd AgRe/ үүсгэж, компанийн үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, богино хэмжээний видео сурталчилгаануудыг /шторк/ нэгтгэн байршууллаа.

Экспортын зээлийн даатгалын бүтээгдэхүүн болох “Нийлүүлэгчийн богино хугацаат зээлийн даатгал”, “Эргэлтийн хөрөнгийн зээлийн даатгал”-ын тухай нийт 3 минутын 2 богино хэмжээний дүрст сурталчилгаа /шторк/-ны зохиолыг бэлдэн, “Том амжилт” ХХК-ийг сонгон хийлгүүлж, олон нийтийн цахим сүлжээнд байршууллаа.

Компанийн цахим хуудас, Экспортын даатгалын газрын цахим хуудас болон нүүр номын /фэйсбүүк/, жиргээ /твиттер/ хуудсандаа компанийн болон даатгалын талаар мэдээллийг түгээж, хоорондын уялдаа холбоотой ажиллуулж байна.

Газар тариалангийн нөхөн төлбөрийн 17 минутын нэвтрүүлгийг 2018 оны 3 дугаар сарын 03, 24-ний өдрүүдэд тус тус МҮОНРТ болон “Монгол HD” телевизийн оргил цагуудаар олон нийтэд түгээлээ.

Компанийн Гүйцэтгэх захирлын Экспортын зээлийн агентлагийн талаар олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой нийтлэл ярилцлагыг “Хөөрөх цэг”, “Forbes”, “Mongolian Economics” сэтгүүлүүдээс үнийн санал авч, “Mongolian economics” сэтгүүлийг сонгон нийтлүүлээ. Мөн ikon.mn сайтад 2018 оны 4 дүгээр сарын 02-ны өдөр онцлох мэдээнд байршуулав.

Сурталчилгааны компаниудаас үнийн санал авсны дагуу “Чөлөөт монгол” студитэй гэрээ байгуулан МИД-ын талаар 20 минутын 10 цуврал жүжигчилсэн радио нэвтрүүлгийг

бэлдүүлээ. Тус нэвтрүүлгүүдийг МҮОНР-ийн эфирээр гэрээнд заасан хуваарийн дагуу 2018 оны 6 дугаар сарын 15-ны өдрөөс 7 дугаар сарын 05-ны өдрийн хооронд давталттай нэвтрүүлэв. Ингэснээр малчдад МИД-ын ач холбогдлыг дэлгэрэнгүй тайлбарлан, даатгалын борлуулалтыг идэвхжүүлэн ажиллалаа.

Компанийн 2017 оны жилийн эцсийн тайлан болон МИД-ын 30,000 ширхэг тараах материал /брошюр/-ыг хэвлүүлэхээр 3 компаниас үнийн санал авсан. Үүнээс шаардлага хангасан хамгийн бага үнийн санал ирүүлсэн Эс Пи Ар /SPR/ ХХК-аар хэвлүүлэв.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас 2018 оны 5 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулсан нээлттэй өдөрлөгт зориулан тариалангийн даатгал болон МИД-ын гарын авлага /брошюр/-ыг хэвлэн үйл ажиллагааг сонирхсон хүмүүс, байгууллагуудад тараасан. Мөн уг гарын авлагыг хөдөө орон нутагт томилолтоор ажиллахдаа малчид болон МИД-ын төлөөлөгч, багийн Засаг дарга нарт хүргэлээ.

Өвөрхангай аймгийн Бүрд сум, Баянхонгор аймгийн Жинст, Бууцагаан сумуудад 2018 оны 9 дүгээр сард томилолтоор ажиллаж, МИД-ын нөхөн төлбөрийн батламж гардуулах, компанийн үйл ажиллагааг танилцуулах зорилгоор сумын Засаг дарга, ИТХ-ын дарга, МИД-ын төлөөлөгч, малчидтай уулзалт хийсэн. Мөн малчид, сумын удирдлагуудаас ярилцлага авч бичлэг хийж бэлтгэв.

МИД-ын нөхөн төлбөрийн танилцуулга бүхий 1 минутын шторкийг “Том амжилт” студитэй гэрээ байгуулан бэлтгэж, компанийн болон орон нутгийн нүүр ном /фэйсбүүк/ хуудсанд байршуулсан.

3.4. Хууль эрх зүйн орчныг сайжруулах ажлын хүрээнд:

Сангийн яаман дээр 2018 оны 5 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулагдсан Даатгалын тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай, Жолоочийн даатгалын тухай зэрэг хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хамтарсан ажлын хэсгийн хуралдаанд оролцож Үндэсний давхар даатгалын компани /ҮДДК/ байгуулах үндэслэл, ач холбогдлын талаар танилцуулга хийв. Уг танилцуулгад компани байгуулах шаардлага, ач холбогдол болон нэмэлтээр Монгол Улсад гамшгийн даатгалын сан байгуулах, уг сан Үндэсний давхар даатгалын компанийн /ҮДДК/-ийн удирдлагад байж болох боломжийн талаар танилцуулсан болно. Мөн ажлын хэсгийн гишүүдэд өөрсдийн бэлдсэн хуулийн урьдчилсан тандах судалгаа, олон улсын туршлагын харьцуулсан судалгаа, “Даатгалын тухай хууль”-д өөрсдийн зүгээс оруулсан зүйл, заалтын төслийг танилцуулсан.

Даатгалын тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсгийн гишүүдэд уг хуулийн төсөлд оруулах давхар даатгалын компанийн үйл ажиллагаатай холбогдох саналын томъёоллыг хүргүүлэв.

Даатгалын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсэгт ажиллаж, хуулийн төсөлд өгөх саналуудыг боловсруулан хүргүүлэв. Уг саналд даатгалын төрлийг амьдралын болон амьдралын бус гэж зааж өгөх, амьдралын даатгал заавал 1 жилээр хязгаарлагдахгүйгээр оруулах, мөн даатгалын компаниуд олон улсын давхар даатгалд шилжүүлэх дүнгийн 5 хувийг дотоодын давхар даатгалын компанид даатгадаг байх, хам даатгалын зохицуулалт зэрэг санал боловсруулан тусгалаа.

Даатгалын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсэг 2018 оны 10 дугаар сарын 29-ний өдөр хуралдаж, ирүүлсэн саналуудыг нэгтгэснийг хэлэлцэв. Ажлын хэсгийн гишүүдийг 3 дэд бүлэгт хуваасан ба тус компанийн төлөөлөл даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсэгт хуваарилагдсан. Хурлаар даатгалын мэргэжлийн

оролцогчийн тухай хуулийг хүчингүй болгож уг хуулийн заалтуудыг даатгалын тухай хуульд оруулахаар болов.

Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-ийн 2018-2020 оны Стратеги төлөвлөгөө, 2018 оны бизнес төлөвлөгөөг боловсруулан Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 02/01 дүгээр тогтоолоор батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Уг төлөвлөгөөнд компани Үндэсний давхар даатгалын компани болон өргөжих, цаашид давхар даатгах даатгалын хэлбэрүүд, бүтээгдэхүүний судалгааг хийсэн болно.

Үндэсний давхар даатгал ХК-ийн 2019-2021 оны бизнес төлөвлөгөөг нэгтгэн боловсруулав. Уг бизнес төлөвлөгөөнд компанийн шинэчлэгдсэн бүтэц, эрх зүйн орчны шинжилгээ, шинэ даатгалын бүтээгдэхүүний танилцуулга, даатгалын хэлбэр бүрээр хийсэн судалгаа, түүний борлуулалтын төлөвлөгөө зэргийг тусгасан.

ДӨРӨВ. ЭКСПОРТЫН ДААТГАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮН

4.1. Экспортын даатгалтай холбогдох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх, сайжруулах ажлын хүрээнд:

Экспортын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа, эрхлэхийг зорьж буй жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжсэн экспортын зээлийн даатгалын үйл ажиллагаа эрхлэхэд холбогдох хууль эрх зүйн баримт бичгийг боловсруулах, сайжруулах санал, зөвлөмж, төсөл боловсруулах ажлын хүрээнд дотоодын 2 зөвлөхийг сонгон шалгаруулж 2018 оны 01 дүгээр сарын 26-ны өдрөөс 12 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл гэрээ байгуулан хамтран ажилласан. Экспортын даатгалын газрын ажилтнууд дотоод зөвлөхүүдтэй хамтран дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Экспортын зээлийн даатгалын хууль эрх зүйн зохицуулалтын асуудалд дүн шинжилгээ хийх;
2. Экспортын зээлийн даатгалын хууль эрх зүйн зохицуулалтын асуудалд шийдвэрлэх зорилгыг томъёолох;
3. Тухайн асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоож, харьцуулах;
4. Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судлах;
5. Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулж, дүгнэлт хийх;
6. Тухайн зохицуулалтын талаарх олон улсын эрх зүйн зохицуулалтыг харьцуулах;
7. Зөвлөмж боловсруулах;
8. Тухайн зохицуулалтын талаарх олон улсын зөвлөх /Андреас Класен-зах зээлийн судалгааг боловсруулсан/-ийн зөвлөмжийг хянах, зөвлөмжид санал оруулах, олон улсын зөвлөлтэй зөвлөлдөх;

Дотоодын зөвлөхүүд зах зээлийн судалгаа хийсэн олон улсын зөвлөх Андреас Класентай цахимаар холбогдож Монгол Улсын экспортын зээлийн даатгалын хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, сайжруулах чиглэлээр зөвшилцөн олон улсын туршлагыг судалсан ба дээрх ажлуудыг гүйцэтгэхдээ олон улсын зөвлөхийн зөвлөмжийг ашигласан.

Монгол Улсын Засгийн газрын баримталж буй хувийн хэвшилд суурилсан эдийн засгийн системийг бүрдүүлэх бодлогын хүрээнд Сангийн яам Экспортын даатгалын охин компани байгуулж, хөрөнгийн оролцоогоор хангах асуудлыг дахин авч үзэх шаардлагатай болсон. Үүний дагуу Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-ийн Экспортын даатгалын газар 1 дүгээр бүрэлдэхүүн хэсгийг үр дүнтэй хэрэгжүүлэх дүн шинжилгээг боловсруулав. Үүнд:

- Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК даатгагчийн хувиар шууд үйлчилгээ үзүүлэх: Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК нь Экспортын даатгалын охин компани /ЭДОК/-ийг байгуулж, экспортлогчдыг шууд даатгах;

- Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК давхар даатгагчийн хувиар шууд бус үйлчилгээ үзүүлэх: Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК нь экспортлогчдод зээлийн даатгалын үйлчилгээг үзүүлж буй дотоодын даатгалын компаниудыг давхар даатгах;

Зах зээлийн багтаамж бага, хөгжил сул орнууд, тухайлбал Монгол Улсын хувьд экспортын даатгалыг зах зээлд нэвтрүүлж, Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд нээлттэй болгоход төрийн оролцоо зайлшгүй шаардлагатай.

Хэрэгжүүлэх хувилбаруудын харьцуулалт: ЭДОК ба ЭДГ

	ХААДД ХК шүүд даатгах	ХААДД ХК давхар даатгах - ЭДГ
Д а в у у т а л	<ul style="list-style-type: none"> ✓ Энгийн үйл ажиллагаа, зөвхөн ганц аж ахуйн нэгж ✓ Олон улсын түршлага элбэг ✓ Экспортлогчдод зөв мэдээлэл хүргэнэ. 	<ul style="list-style-type: none"> ✓ Хувийн даатгалын салбарыг хөгжүүлж, дэмжинэ ✓ ХААДД ХК-ийн одоогийн үйл ажиллагааны бүтцийг ашиглана ✓ Шинэ төрийн байгууллага байгуулах шаардлагагүй ✓ Улс төрийн хөндлөнгийн нөлөө бага.
С у л т а л	<ul style="list-style-type: none"> × Шинэ компанийн нэмэлт зардал × Улс төрийн сөрөг нөлөө их 	<ul style="list-style-type: none"> × Илүү төвөгтэй, хоёр аж ахуйн нэгжээр дамжуулан хүргэнэ. × Дотоодын даатгал болон олон улсын давхар даатгалын компанитай хураамжийн орлогоо хуваана.

Нарийвчилсан тооцоолол болон Засгийн газрын баримталж буй бодлогод үндэслэн хоёр хувилбарыг харьцуулж үзсэний үр дүнд Сангийн яам зээлийн даатгалыг Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК давхар даатгаж, шууд бус үйлчилгээ үзүүлэх нь оновчтой гэсэн шийдвэрт хүрлээ. Хэрэгжилтийн шинэ хувилбарын хүрээнд хийсэн тооцооллын дагуу Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-д оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ 9.0 сая ам.доллороос 5.0 сая ам.доллар болон буурч, уг хөрөнгийг 3 бус 2 удаагийн санхүүжилтээр олгох ба эхний 3.0 сая долларын санхүүжилтийг 3.0 сая долларын эрсдэлд өртөх байдлыг хамгаалах зорилгоор, хоёр дахь удаагийн 2.0 сая долларын санхүүжилтийг нэмэлт 2.0 сая доллар /нийт 5.0 сая доллар/-ын эрсдэлд өртөх байдлыг хамгаална.

Олон Улсын Хөгжлийн Ассоциацийн санхүүжилттэй зээлийг зөвхөн экспортын даатгалын үйл ажиллагааг эрхлэхэд тусгайлан зориулагдсан даатгалын нөөц санг бүрдүүлэх, эрсдэлийг санхүүжүүлэхэд хөрөнгийн оролцоо /Quasi-equity/ хэлбэрээр Сангийн яамнаас Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-д олгоно. Энэхүү хөрөнгийг экспортын даатгалын нөхөн төлбөрийг барагдуулахад ашиглана.

Экспортын даатгалын тогтолцоог олон улсын жишигт тохируулан нэвтрүүлж, хэрэгжүүлэхийн тулд экспортын даатгалын бүтээгдэхүүнийг боловсруулахад техник туслалцаа үзүүлэх, давхар даатгал, мэдээллийн үйлчилгээ, авлага цуглуулах, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, чиглэлээр хамтран ажиллах олон улсад тэргүүлэгч байгууллагыг сонгон шалгаруулж мастер гэрээ байгуулах, түүнчлэн уг мастер гэрээний ажлын даалгаврын төслийг боловсруулах, мастер гэрээний хэрэгжилтэд техникийн туслалцаа өгч ажиллах олон улсын зөвлөх үйлчилгээ авах нэн шаардлагатай байна.

Монгол Улсад экспортын даатгал хийх эрх зүйн орчныг бүрдүүлэхийн тулд экспортын даатгалын газрын ажилтнууд бусад туршлагатай улсын /Швейцар, Япон, Солонгос, ОХУ, Дани, Канад/ хууль тогтоомжтой танилцаж орчуулга хийсэн. Эдгээрт үндэслэн дотоодын зөвлөхүүд олон улсын харьцуулсан судалгааг боловсруулсан.

Экспортын даатгалын үйл ажиллагааг төр хувийн хэвшлийн түншлэлийн оролцоог хангах замаар буюу дотоодын даатгалын компаниар дамжуулан аж ахуйн нэгжүүдийг даатган, Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК давхар даатгаж хэрэгжүүлэхэд төслийн холбогдох бичиг баримтуудад өөрчлөлт оруулах шаардлагатай байна. Үүнд:

- Монгол Улс, Олон Улсын Хөгжлийн Ассоциаци хооронд 2016 оны 8 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан Санхүүжилтийн хэлэлцээр;
- Олон Улсын Хөгжлийн Ассоциаци, Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК хооронд 2016 оны 8 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан Төслийн гэрээ;

Экспортын зээлийн даатгалын институцийг хөгжүүлэх, мастер гэрээний цар хүрээг тодорхойлох Олон улсын зөвлөх Жеф Винсент нь ажлын даалгаварт тусгагдсаны дагуу Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-д 2018 оны 5 дугаар сарын 28-31-ний өдрүүдэд ажиллалаа. Энэ хугацаанд Экспортын даатгалын газрын ажилтнууд болон дотоодын зөвлөхүүдтэй уулзалт, ярилцлага зохион байгуулж, санал солилцов.

Олон улсын зөвлөх Жеф Винсент дотоодын хуулийн зөвлөхүүдийн боловсруулсан тайлангуудыг хянаж үзээд хууль, эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр зөвлөмж боловсруулсан. Уг зөвлөмжид экспортын зээлийн даатгалын хууль, эрх зүйн орчныг сайжруулж, бүрдүүлэхэд тухайн бүтээгдэхүүний онцлогийн үүднээс харгалзан үзэх ёстой чухал сэдвүүдийг тусгасан. Тухайлбал, экспортын даатгалд хамрагдаж буй дан зээлдэгчийн зээлийн хэмжээний өсөлт, чанаргүй зээлээс зайлсхийх заалт, даатгалын хураамжийг банкны шимтгэлд оруулахгүй байх, улсын баталгаа, даатгалын хураамжаас авах татаас, нэмэлт үйлчилгээ үзүүлж орлого олох боломж, нөөц сангийн аргачлал, авлага цуглуулах заалт, хөрөнгийн өр төлбөрийн харьцаа, гадаад валютаар хөрөнгө оруулалт хийх боломж, бүтээгдэхүүн загварчлах болон өөрчлөлт хийх боломж, төлбөрийн чадварын журам дахь давхар даатгалын нөлөөлөл, компанийн засаглалын бүтэц гэх мэт.

4.2. Олон улсад тэргүүлэгч байгууллагатай мастер гэрээ байгуулан хамтран ажиллах чиглэлээр:

Экспортыг дэмжих төслийн нэгдүгээр бүрэлдэхүүн хэсгийн 2018 оны Худалдан авалтын төлөвлөгөө болон ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Мастер гэрээ байгуулах олон улсын хамтрагчийн Ажлын даалгаврын төслийг боловсруулж, мастер гэрээ байгуулагдах хүртэл техник туслалцаа үзүүлэх зөвлөх үйлчилгээг олон улсын хоёр зөвлөхөөр гүйцэтгүүлэхээр 2 ажлын даалгавар бэлтгэн Дэлхийн банкны мэргэжилтнээр хянуулж, зөвшөөрөл авсан.

Экспортыг дэмжих төслийн нэгдүгээр бүрэлдэхүүн хэсгийн хураангуй жагсаалтад орсон зөвлөхүүдийн туршлага, мэдлэгт үндэслэн эдгээр ажлыг нэгтгэж нэг зөвлөхөөр хийлгүүлснээс салгаж хоёр зөвлөхөөр хийлгүүлэх нь илүү үр дүнтэй гэж Дэлхийн банкны мэргэжилтэн Арнауд Дорнелтай зөвшилцсөний үндсэн дээр шийдвэрлэсэн.

Экспортын зээлийн даатгалын институцийг хөгжүүлэх, мастер гэрээний цар хүрээг тодорхойлох Олон улсын зөвлөх нь Жеф Винсент 2017 онд олон улсын зөвлөх ноён Андреас Класены боловсруулсан хоёр тайланд дүн шинжилгээ хийлээ. Экспортын даатгалын үйл ажиллагааны цар хүрээ, аутсорсингийн хэлбэрт дүн шинжилгээ хийсний үндсэн дээр мастер гэрээний цар хүрээг тодорхойлсон тайланг боловсруулсан. Өөрөөр хэлбэл, экспортын даатгалын үйл ажиллагааг нэвтрүүлж, даатгалын үйл ажиллагааг

эрхлэхэд шаардагдах хүчин зүйлс болох дүрмийн сан, харилцаа холбоо-маркетинг, даатгалын гэрээний загвар-хэллэг, бизнес хөгжил, арилжааны ба эрсдэлийн андеррайтинг, зээл болон даатгалын мэдээлэл, улс орны болон салбарын эрсдэлийн үнэлгээ, давхар даатгал, нягтлан бодох бүртгэлийн удирдлага, портфелийн удирдлага, мэдээллийн технологи, авлага цуглуулга, нөхөн төлбөр, хөрөнгө оруулалтын удирдлага, эрсдэлийн удирдлагын хүрээ, хүний нөөц, санхүү ба нягтлан бодох бүртгэл, дотоод аудит, хууль эрх зүйн орчин зэрэгт дүн шинжилгээ хийсэн.

Мастер гэрээний цар хүрээг тодорхойлсон товч танилцуулгыг монгол хэлээр бэлтгэн Сангийн яамны Санхүүгийн бодлогын газарт хүргүүлсэн. Түүнчлэн гэрээний ач холбогдол, цар хүрээг танилцуулах зорилгоор Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын хамт олонтой 3 удаа уулзалт зохион байгуулсан. Төслийн удирдагч Үллэ Лохмус, техникийн зөвлөх Арнауд Дорнел, Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Энхтайван нар Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогттой уулзаж бүрэлдэхүүн хэсгийн хэрэгжилт, мастер гэрээний цар хүрээг танилцуулж, санал солилцлоо. Төрийн нарийн бичгийн дарга мастер гэрээний цар хүрээтэй танилцаж, худалдан авалтыг хуваан зохион байгуулж болох талаар саналаа илэрхийллээ.

Олон улсын зөвлөх Жеф Винсентийн боловсруулсан Мастер гэрээний цар хүрээг тодорхойлох тайланг Дэлхийн банкны техникийн зөвлөх Арнауд Дорнелтой ярилцаж, санал солилцов. Дэлхийн банкны ажлын хэсэг, Төсөл хэрэгжүүлэх нэгж, Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК хамтарсан уулзалтаар Мастер гэрээний ажлын даалгаврын төслийг боловсруулах олон улсын зөвлөхийн ажлын даалгаварт нэмэлт ажлыг тусгаж, нэг эх үүсвэрийн аргаар худалдан авалтын үйл ажиллагааг зохион байгуулахаар тохиролцов.

Мастер гэрээний дараах багцуудаар дамжуулан эдгээр үйлчилгээг авна. Үүнд:

- Харилцаа холбоо, бизнес хөгжил, даатгалын гэрээний загварчлал, улс орны болон салбарын эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийн ба арилжааны андеррайтинг, эрсдэлийн ба портфелийн удирдлага, мэдээллийн удирдлага, авлага цуглуулга ба нөхөн төлбөрийн удирдлагад чиглэсэн сургалт болон системээр дамжуулан “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн чадавхыг бэхжүүлнэ.
- Давхар даатгалаар дамжуулан андеррайтингийн чадавх, хөрөнгө, эрсдэлийн удирдлагын сахилга батыг сайжруулна.
- Мэдээллийн үйлчилгээгээр дамжуулан худалдан авагчийн зээлийн түүх, зээлийн санал, зээлжих дээд хязгаарын мэдээллийг авна.
- Олон улсын хамтран ажиллагч байгууллагаар дамжуулан гадаадын худалдан авагчийн хоцрогдсон төлбөрийн авлагыг цуглуулна.

Мастер гэрээний ажлын даалгаврын төслийг эцэслэн боловсруулж, гэрээний хэрэгжилтэд техникийн туслалцаа өгч ажиллах олон улсын зөвлөхийн ажлын даалгаврыг боловсруулж эцэслэн худалдан авалтын баримт бичгүүдэд Дэлхийн банкны зөвшөөрлийг авахаар Төсөл хэрэгжүүлэх нэгжид хүргүүлэв.

4.3. Даатгуулагчдын шаардлага, хэрэгцээнд нийцсэн экспортын зээлийн даатгалын бүтээгдэхүүнийг боловсруулах ажлын хүрээнд:

Дэлхийн банкны Экспортыг дэмжих төслийн удирдагч хатагтай Үллэ Лохмусаар ахлуулсан ажлын хэсэг 2018 оны 5 дугаар сарын 23-31-ний өдрүүдэд Монгол Улсад ажиллаж төслийн хэрэгжилтэд зөвлөмж, чиглэл өгөв. Нэгдүгээр бүрэлдэхүүн хэсгийн хэрэгжилт, цаашид хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө болон экспортын даатгалыг Монгол Улсад хэрэгжүүлэх хувилбарыг Сангийн яаманд танилцуулж, шийдвэр гарган Дэлхийн банканд хүргүүлэхийг зөвлөлөө.

Олон улсын зөвлөх Жеф Винсент манай компани дээр ажиллаж, Монгол Улсад Экспортын зээлийн агентлаг байгуулагдвал тээвэрлэлтийн өмнөх болон дараах даатгалыг борлуулахаас гадна экспортлогчдод худалдан авагчдыг нь судалж өгөх, гаднын харилцагч Экспортын зээлийн агентлагт дотоодын нийлүүлэгчдийн мэдээлэл зарах, зээлийн үнэлгээ хийх, дотоодын худалдааны даатгал, импортын факторингийн даатгал хийх, авлага цуглуулах зэргээр ажиллах боломжтой талаар зөвлөмж өгсөн.

Олон улсын зөвлөх Жеф Винсент болон Дэлхийн банкны мэргэжилтэн Арнауд Дорнел, Бизнес хөгжил, төслийн газрын дарга Б.Батбаяр нар Зээлийн батлан даалтын сан, Худалдаа хөгжлийн банк, Хаан банкны Жижиг дунд үйлдвэрлэл, бизнесийн албаны мэргэжилтнүүдтэй уулзалт зохион байгуулж, Хаан банкнаас зээл авч буй жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн нийт багц, чанаргүй зээлийн хувь болон зээлийн хүүгийн тухай мэдээлэл авав. Мөн тээвэрлэлтийн өмнөх болон дараах даатгалын бүтээгдэхүүнийг банкаар дамжуулан борлуулах боломж зэргийн талаар ярилцсан. Зөвлөхүүдийн таамгаар банкаар дамжуулан нийт борлуулалтын 80 хувь нь хийгдэх тул хамтын ажиллагаа зайлшгүй чухал юм.

Экспортын даатгалын газраас Экспортын даатгалыг хэрэгжүүлэгч байгууллагын хувилбарыг танилцуулсан төслийг Сангийн яамны Даатгалын хэлтсийн дарга болон мэргэжилтнүүд, Сангийн яамны Зээл тусламжийн газрын дарга нарт танилцуулсан ба уг танилцуулгаар дамжуулан төслийг хэрэгжүүлэх үндэслэл, шаардлага, нийцтэй болон тогтвортой байдал, экспортын даатгалыг хэрэгжүүлж болох хувилбар, тэдгээрийн санхүүгийн төсөөлөл зэргийг танилцууллаа.

Ижил төстэй үйл ажиллагаа бүхий экспортын даатгалын агентлагуудын даатгалын бүтээгдэхүүний гэрээний төсөл, өргөдлийн маягыг орчуулан танилцуулав.

Экспортын даатгалын бүтээгдэхүүний танилцуулга болон эргэлтийн хөрөнгийн даатгалын бүтээгдэхүүний танилцуулгыг бэлтгэв. Экспортын зээлийн даатгалын гарын авлагыг англи хэл рүү хөрвүүлээ.

Шинэ бүтээгдэхүүнийг нэвтрүүлэхэд зах зээлд оролцогчдын цар хүрээ, учирч болох эрсдэлийг тодорхойлж, барьцаа хөрөнгө, зээлийн хүү, ханшийн хэлбэлзэл, төлбөрийн чадварын эрсдэл болон тээвэрлэлтийн эрсдэлүүдийг судлан үйл ажиллагааны гарын авлага боловсруулахад ашиглав.

“Монгол-Оросын санаачилга-2018” форумын хүрээнд “Монгол-Оросын хөрөнгө оруулалтын салбар дахь хамтын ажиллагааны чуулган”-д оролцож, Олон улсын хөгжлийн банкнуудын экспортыг дэмжих боломж, ОХУ-ын Экспортын төв, Орос-Монголын гадаад эдийн засгийн төслүүдийг дэмжих санхүүгийн хэрэгслүүд, Монгол Улсын гадаадын хөрөнгө оруулалт, санхүүгийн зах зээлийн хууль эрх зүйн зохицуулалт, хоёр улсын банк санхүүгийн салбарын хамтын ажиллагааны боломжуудын талаар илтгэл хэлэлцүүлгүүдийг сонсов.

Компанийн Экспортын даатгалын газрын цахим хуудсанд тавигдаж буй шинэ мэдээ мэдээллийг англи хэл рүү хөрвүүлж байна. Экспортын даатгалын газрын цахим хуудсыг хөгжүүлэх, агуулгыг уншиж, нягтлах, засварлах ажлыг хариуцан гүйцэтгэж байна.

Олон улсын зээлийн даатгал, баталгааны холбоо /ICISA/-ны хэвлэсэн Экспортын даатгалын нэр томъёоны толь бичгийг англи хэлнээс монгол хэл рүү хөрвүүлээ.

Төслийн хэрэгжилтийн үр дүнг хэмжих, хянах зорилт бүхий /Project Implementation Monitoring Information System-PIMIS/ мэдээллийн системийг хөгжүүлснээр Бүрэлдэхүүн хэсэг 1-ийн хэрэгжилтийн явцад дараах давуу талууд бий болж байна. Үүнд:

1. Бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хөгжүүлсэн экспортын санхүүгийн бүтээгдэхүүнээс ашиг шим хүртэгчдийн дэлгэрэнгүй мэдээлэл бүхий бүртгэлийн сан үүсэх;
2. Даатгуулагчийн даатгалын гэрээний дугаар, даатгалын бүтээгдэхүүний төрөл, төлсөн хураамжийн хэмжээ болон олгосон нөхөн төлбөрийн хэмжээг даатгалын гэрээ тус бүрээр бүртгэснээр хураамж болон нөхөн төлбөрийн түүхийн дүн шинжилгээ гаргах;
3. Даатгуулагчийн экспортын орлогын өсөлтийг тодорхойлох;
4. Даатгалд хамрагдсанаар экспортын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж эхэлсэн Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг бүртгэх, үр дүнг хэмжих;
5. Даатгалын бүтээгдэхүүн даатгуулагчийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхийг тодорхойлох;
6. Даатгуулагчдын экспортын үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээлэл бүхий бүртгэлийн сан үүсэх;
7. Даатгалын гэрээ тус бүрийн явцын мэдээллийг бүртгэж, хянах.

Сонгосон бүтээгдэхүүнүүдэд зориулсан андеррайтингийн гарын авлага, үйл ажиллагааны гарын авлага боловсруулах ажлын хүрээнд:

Зах зээлд нэвтрүүлэх хоёр бүтээгдэхүүнд суурилан экспортын даатгалыг хэрэгжүүлэх байгууллагын бизнесийн үйл ажиллагааг зохицуулах үйл ажиллагааны гарын авлагыг боловсрууллаа. Уг гарын авлага нь

1. Экспортын даатгалыг хэрэгжүүлэх байгууллагын компанийн засаглал, удирдлага, тэдний эрх, үүргийн цар хүрээ
2. Андеррайтингийн эрсдэлийн хүрээ
3. Андеррайтингийн үйл ажиллагааны журам
4. Даатгалын гэрээний үйлчилгээний журам
5. Нөхөн төлбөрийн үйл ажиллагааны журам бүхий 5 модулаас бүрдсэн.

Дараагийн шатанд даатгалын үйл ажиллагааны хэрэгжилт, хууль эрх зүйн орчны өөрчлөлт зэрэг бодит жишээнд тулгуурлан гарын авлагад нэмэлт, өөрчлөлт оруулна.

Дэлхийн банкны Экспортыг дэмжих төслийн удирдагч хатагтай Үллэ Лохмусаар ахлуулсан ажлын хэсэг 2018 оны 9 дүгээр сарын 24-28-ны өдрүүдэд Монгол Улсад ажиллаж төслийн дунд хугацааны үнэлгээг хийлээ.

Дэлхийн банкны ажлын хэсэг төслийн дунд хугацааны үнэлгээ хийх гэж байгаатай холбогдуулан Төслийг хэрэгжүүлэх нэгжийн ажилтнууд, “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн удирдлагатай цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөлдөн бүрэлдэхүүн хэсгийг хэрэгжүүлэх хувилбар, харьцуулсан үнэлгээ, цаашдын үйл ажиллагааг тусгасан Дүн шинжилгээний тайланг боловсруулахаар тохиролцов.

Экспортын зээлийн даатгалын тухай мэдээлэл өгөх зорилгоор Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-тай хамтран ажилладаг даатгалын компаниудтай уулзалт хийж, экспортын зээлийн даатгал, зах зээлийн талаар мэдээлэл өгсөн. Уг уулзалтад Монгол даатгал ХХК, Бодь даатгал ХХК, МИГ даатгал ХХК, Тэнгэр даатгал ХХК, Монре даатгал ХХК-ийн шинэ бүтээгдэхүүн хариуцсан ахлах мэргэжилтнүүд оролцсон бөгөөд даатгалын компаниудын төлөөллүүд экспортын даатгалд оролцох хүсэлт, холбогдох материал, чадавх бэхжүүлэх сургалтад хамрагдах сонирхлоо илэрхийлсэн.

Ажлын хэсгийн айлчлалын хүрээнд дараах үр дүнд хүрэв. Үүнд:

- Дэлхийн банкны техникийн зөвлөх Арнауд Дорнелтай хамтран экспортын даатгалыг хэрэгжүүлэх хоёр хувилбарын танилцуулга, харьцуулалт, бизнес төсөөлөл, мастер гэрээ, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ зэрэг агуулгыг багтаасан танилцуулга илтгэлийг боловсруулав. Дэлхийн банк, Сангийн яам, Төсөл хэрэгжүүлэх нэгж, Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-ийн хамтарсан уулзалтаар хэлэлцсэний үр дүнд

Экспортын даатгалыг Экспортын даатгалын охин компани байгуулахгүйгээр буюу өнөөгийн нөөц бололцоогоо ашиглан, төр хувийн хэвшлийн оролцоог хангах замаар Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-ийн Экспортын даатгалын газар удирдан зохион байгуулах нь зүйтэй гэсэн дүгнэлтэд хүрлээ. Ингэснээр зах зээлд нэвтрүүлэх экспортын даатгалын бүтээгдэхүүнийг хувийн даатгалын компаниудаар дамжуулан борлуулж, Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК давхар даатгана.

- Төр хувийн хэвшлийн оролцоог хангах замаар экспортын даатгалын үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд холбогдох гэрээ, хэлэлцээрийн заалтуудад өөрчлөлт оруулах шаардлагатай. Үүний хүрээнд төслийн удирдагч Үллэ Лохмус, техникийн зөвлөх Арнауд Дорнел нартай Дэлхийн банкны зүгээс төслийн 1.2 бүрэлдэхүүн хэсэгт оруулах хөрөнгийн оролцооны дүн, тавигдах шаардлагыг хэрхэн өөрчлөх талаар хэлэлцэж, шийдэлд хүрлээ. Сангийн яам болон Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-ийн хооронд Санхүүжилтийн гэрээг байгуулах шаардлагатай. Энэхүү гэрээний хүрээнд Дэлхийн банкны санхүүжилттэй зээлийг Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-д зөвхөн экспортын зээлийн даатгалын үйл ажиллагааг эрхлэхэд тусгайлан зориулагдсан даатгалын нөөц санг санхүүжүүлэх хөрөнгийн оролцоо хэлбэрээр олгоно /Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-д зээл хэлбэрээр олгох боломжгүй/. Энэхүү хөрөнгийн оролцоо 2 удаагийн санхүүжилтээр олгогдоно. Эхний 3.0 сая долларын санхүүжилтийг 3.0 сая долларын эрсдэлд өртөх байдлыг хамгаалах зорилгоор олгоно. Хоёр дахь удаагийн 2.0 сая долларын санхүүжилтийг нэмэлт 2.0 сая доллар /нийт 5.0 сая доллар/-ын эрсдэлд өртөх байдлыг хамгаалах зорилгоор олгоно. Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан болон олгосон хөрөнгийн оролцооны дансны тайлан, балансыг Дэлхийн банкны санхүүгийн удирдлагын шаардлагын дагуу тайлагнана.
- Дэлхийн банкны техникийн зөвлөх Арнауд Дорнелын хамтаар Монгол даатгал ХХК, Мандал даатгал ХХК, Говь ХК-тай уулзалт зохион байгуулж, экспортын даатгал, экспортын даатгалыг хэрэгжүүлэх арга замын талаар танилцуулж, санал солилцлоо. Экспортыг дэмжих төслийн ахлагч Үллэ Лохмус, техникийн эксперт Арнауд Дорнелтэй хамт Мандал даатгал ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Жавхлантай уулзаж Экспортыг дэмжих төсөл, экспортын зээлийн даатгалын талаар танилцуулан Мандал даатгал ХХК-ийн зүгээс экспортын зээлийн даатгалд хамтран ажиллах сонирхол байгаа эсэх талаар ярилцав. Мандал даатгал ХХК-ийн зүгээс Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК уг даатгалыг удирдан зохион байгуулбал анхлан даатгагчаар хамтран ажиллах сонирхолтой байгаагаа илэрхийлсэн.

Экспортыг дэмжих төслийн техникийн эксперт Арнауд Дорнелтай хамт Монгол Улсын уул уурхайн бус салбарын тэргүүлэгч экспортлогч болох Говь ХК-ийн хилийн чанад дахь худалдааны албаны дарга Н.Базаррагчаатай уулзаж экспортын даатгалын талаар мэдээлэл өгсөн. Говь ХК-ийн зүгээс гадаад худалдааны болон худалдан авагчдын талаарх мэдээлэл авав. Уулзалтаар экспортын зээлийн даатгалын бүтээгдэхүүн бэлэн болмогц дахин танилцуулахаар болов.

4.4. Шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд амжилттай нэвтрүүлэх үүднээс ажилтнуудын мэдлэг, чадавхыг хөгжүүлэх ажлын хүрээнд:

Монгол Улс, Олон Улсын Хөгжлийн Ассоциаци хооронд байгуулсан Санхүүжилтийн хэлэлцээрийн дагуу экспортыг дэмжих төслийн нэгдүгээр бүрэлдэхүүн хэсгийн хэрэгжилтийн хүрээнд Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-ийн экспортын даатгалын газрын ажилтнуудыг экспортын зээлийн даатгалаар мэргэшүүлж, чадавхыг бэхжүүлнэ. Нэгдүгээр бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд олон улсын тэргүүлэгч байгууллагатай байгуулах мастер гэрээнд чадавх бэхжүүлэх багцыг нэгтгэн оруулахаар төлөвлөсөн. Ингэснээр мастер гэрээний хүрээнд ихэнх сургалт, дадлагыг зохион байгуулж, шаардлагатай бусад сургалтыг тухай бүрд нь төслийн удирдагч, захиралд танилцуулж, зөвшөөрөл авна.

Газар тус бүрээс нийт ажилтнууддаа хийх сургалтын төлөвлөгөөний хуваарийн дагуу Бизнес хөгжлийн газрыг төлөөлж экспортын зээлийн даатгал, үүнд хэрэглэгчийн зээлийн даатгал болон эргэлтийн хөрөнгийн даатгалын бүтээгдэхүүний талаар холбогдох ойлголт өгөх зорилго бүхий “Худалдааны зээлийн даатгал” илтгэлийг Гадаад харилцаа, хамтын ажиллагааны ажилтан Г.Нямдаваа компанийн ажилтнуудад 2018 оны 2 дугаар улиралд бэлдэн, сургалт танилцуулга хийв.

Олон улсын зөвлөх Жеф Винсент Монгол Улсад экспортын даатгалыг нэвтрүүлж, хэрэгжүүлэх боловсон хүчний чадавхыг бэхжүүлэх чиглэлээр зөвлөмж боловсруулан, экспортын даатгалын үйл ажиллагаа эрхлэхэд шаардагдах сургалтын агуулгыг багцлан тодорхойлж, эдгээрийг ямар хэлбэрээр эзэмшвэл зохих талаар тусгасан сургалтын хэрэгцээ, шаардлагын үнэлгээг боловсруулан Экспортын даатгалын газрын ажилтнуудад танилцуулсан.

Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-ийн Бизнес хөгжил, төслийн газрын дарга Б.Батбаяр Франц Улсад 2018 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс 21-ний өдрүүдэд Бернийн холбооны Праг клубын гишүүн компанийн төлөөлөгчийн хувиар тус холбооны Жилийн уулзалтад оролцож нөхөн төлбөр, давхар даатгал, санкцийн техникийн хандлага, худалдааны дайны талаар хэлэлцлээ.

Факторинг, Нийлүүлэгчийн сүлжээ ба авлагын санхүү, факторингийн эрсдэлийн удирдлага, факторинг ба зээлийн даатгал, даатгалын залилангаас сэргийлэх туршлага, экспортын авлагын хасалт зэрэг нь уулзалтын гол сэдвүүд байв. Бернийн холбооны зочин байгууллагын статус 2 жил хүртэлх хугацаанд үргэлжилдэг. Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК нь 2017 оны Хаврын уулзалтад оролцож тус холбооны зочин байгууллагаар элссэн тул энэ удаагийн жилийн уулзалт зочин байгууллагын хувьд оролцох эрхтэй сүүлийн арга хэмжээ юм. Цаашид тус холбооны гишүүн байхын тулд Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК нь экспортлогчдод чиглэсэн холбогдох үйлчилгээг үзүүлэх эрхтэй Засгийн газрын байгууллага мөн болохыг гэрчилсэн албан ёсны бичиг баримтыг хавсаргасан өргөдлийн маягтыг хүргүүлнэ. Ажиглагч гишүүнээр элсэх үйл явц дараах шат дарааллаар явагдана. Үүнд:

1. Бернийн холбооны Праг клубын тэргүүн болон дэд тэргүүний эерэг дүгнэлт, саналыг авах;
2. Праг клубын эерэг дүгнэлт, санал /уулзалт эсвэл цахимаар хийсэн санал асуулгын үр дүнд суурилсан/-ыг авах;
3. Бернийн холбооны Удирдлагын хорооны зөвшөөрөл авах;
4. Бернийн холбооны үндсэн уулзалтууд дээр хүсэлт гаргагч бүх оролцогчдод хандан илтгэл тавих;
5. Бүх нийтийн санал асуулга /уулзалтын дараах цахим санал асуулга/ явуулах;

Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК Праг клубын гишүүдэд танилцуулга хийж, санал хураалт явуулж болох дараагийн уулзалт 2019 онд Сингапур улсад зохиогдох Хаврын уулзалт бөгөөд санал хураалт явагдах хүртэл цаашид аливаа үйл ажиллагаанд оролцох боломжгүй. Ажиглагч гишүүнээр элсэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

4.5. Олон улсын болон төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх ажлын хүрээнд:

Экспортын чиглэлээр мэргэшсэн олон улсын нэр хүнд бүхий байгууллага, холбоодтой хамтын ажиллагааг хөгжүүлэх:

Герман Улсын Оффенбургийн Их сургуулийн дэргэдэх Худалдаа, Инновацийн институттай бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн ажилд зөвлөмж авч, хамтран ажиллаж байна.

ОХУ-ын Экспортын даатгалын агентлаг /EXIAR/-ийн төлөөлөгчтэй уулзалт хийж, компанийн үйл ажиллагаа, экспортын шинэ төрлийн бүтээгдэхүүн боловсруулж байгаа талаар танилцуулаад цаашид хамтран ажиллах тал дээр санал солилцов.

Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК БНХАУ-ын Экспортын зээлийн даатгалын корпорац САЙНОШҮР /SINOSURE/-ийн Эрсдэлийн удирдлагын газар, Эрсдэлийн судалгааны төв, ОХУ дахь салбарын төлөөлөлтэй 2018 оны 7 дугаар сарын 20-ны өдөр уулзалт хийлээ. Уулзалтаар байгууллагынхаа үйл ажиллагааг танилцуулан, Монгол Улсын экспортын одоогийн нөхцөл байдал болоод экспортлогч аж ахуй нэгж, иргэдэд экспортын даатгалыг авч хэрэгжүүлснээр экспортын төрөлжилт, эдийн засгийн хөгжил болон ажил эрхлэлтэд ямар ач холбогдолтой болох тухай ярилцаж, цаашид хилийн чанадын худалдан авагчдын зээлийн мэдээллийг солилцох, туршлага судлах чиглэлээр хамтран ажиллах нөхцөлийг хэлэлцэв. Тус байгууллагын зээлийн мэдээллийн санд 10 сая компани, 40 мянган банк, 800 гаруй салбарын талаар мэдээлэл байдаг ба 200 гаруй бүс нутаг, улсын эрсдэлийн тайлан, авлага цуглуулах сувагтай.

Түүнчлэн БНЭУ-ын Экспортын зээлийн даатгалын корпорац /ECGC/-тай худалдааны даатгалыг хөгжүүлэх замаар хоёр улсын худалдааг дэмжих зорилгоор хамтын ажиллагааны санамж бичиг байгуулав. Уг санамж бичгийг байгуулснаар:

- Хоёр талын хүсэлтийн дагуу зээл авагч, банк, салбар болон бүс нутгийн мэдээллээр хангах;
- Чадавх бэхжүүлэх болон үйл ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр харилцан туслалцах;
- Шаардлагатай тохиолдолд хам даатгал болон давхар даатгалын гэрээ байгуулах, харилцан ашигтай хамтран ажиллах боломж бүрдлээ.

БНКазУ-ын Казах Экспорт компанитай хамтын ажиллагаа хөгжүүлэх зорилгоор санамж бичгийн төсөл боловсруулан талууд харилцан саналаа өөрчлөх болон нэмэлтээр оруулж, санамж бичиг байгуулах эцсийн шатанд хүрээд байна.

Гадаад харилцааны яам болон Олон улсын худалдааны байгууллагын ажлын хэсгийн 2018 оны 8 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулсан экспорт болон худалдаа хөрөнгө оруулалтын чиглэлээр ажиллаж байгаа холбогдох яам, газар, төрийн бус байгууллага, төсөл хөтөлбөрүүдтэй хийсэн уулзалтад оролцож, санал, мэдээлэл солилцов. Гадаад харилцааны яаман дээр хэрэгжиж байгаа Олон улсын худалдааны байгууллагын төсөл хөтөлбөр нь Монгол Улсын “Үндэсний экспортын стратеги” болон Гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын замын зураглал /Trade and Investment Road Map/-ыг боловсруулах зорилтот төсөл юм.

ТАВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЛОГО, САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

5.1. Компанийн сангийн хөрөнгийг удирдах, зохицуулах чиглэлээр

“Хөрөнгө зохицуулах журам”-ын 4.1-д заасны дагуу Гүйцэтгэх захирлын 2017 оны 5 дугаар сарын 03-ны өдрийн 04/39 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2018 онд нийт 18 удаа хуралдаж, хөрөнгө оруулалтын өгөөжөөс 4.1 тэрбум, улсын төсвөөс бүрдүүлдэг дээд түвшний эрсдэлээс хамгаалах сангийн 0.4 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтын багцад нэмж нийт 45.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын багцыг бүрдүүлэн ажиллалаа. Тайлант онд нийт 6.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын өгөөжийг бүрдүүлсэн.

2018 оны 2 дугаар сарын 13-ны өдөр Гүйцэтгэх захирлын 04/08 дугаар тушаалаар Төрийн банканд 1.5 тэрбум төгрөгийг жилийн 15.28 хувийн хүүтэйгээр, Хаан банканд 1.25

тэрбум төгрөгийг жилийн 15.1 хувийн хүүтэйгээр, Богд банканд 1.25 тэрбум төгрөгийг жилийн 14.8 хувийн хүүтэйгээр тус тус 1 жилийн хугацаатай байршуулсан.

Гүйцэтгэх захирлын 2018 оны 04/14 дүгээр тушаалаар 2 тэрбум төгрөгийг Үндэсний хөрөнгө оруулалтын банканд жилийн 14.0 хувийн хүүтэйгээр, Гүйцэтгэх захирлын 04/16 дугаар тушаалаар 1.0 тэрбум төгрөгийг Улаанбаатар хотын банканд жилийн 14.3 хувийн хүүтэйгээр тус тус 1 жилийн хугацаатай байршуулав.

Гүйцэтгэх захирлын 5 дугаар сарын 10-ны өдрийн 04/30 дугаар тушаалаар 5.0 тэрбум төгрөгийг Төрийн банканд жилийн 14.6 хувийн хүүтэйгээр 0.5 тэрбум төгрөгийг Хаан банкны 5038065617 тоот гэрээний 3.9 дэх заалтын дагуу нэмж, 5 дугаар сарын 31-ний өдрийн 04/37 дугаар тушаалаар 5.0 тэрбум төгрөгийг Богд банканд жилийн 13.0 хувийн хүүтэйгээр, 1.5 тэрбум төгрөгийг Хаан банканд жилийн 12.8 хувийн хүүтэйгээр байршуулж, 6 дугаар сарын 04-ний өдрийн 04/38 дугаар тушаалаар 5.5 тэрбум төгрөгийг Улаанбаатар хотын банканд жилийн 13 хувийн хүүтэйгээр, 1.7 тэрбум төгрөгийг Хас банканд жилийн 12.5 хувийн хүүтэйгээр тус тус байршууллаа.

Гүйцэтгэх захирлын 8 дугаар сарын 10-ны өдрийн 04/47 дугаар тушаалаар 0.5 тэрбум төгрөгийг Хаан банкны 5038065617 тоот хадгаламжийн гэрээний 3.9 дүгээр заалтыг үндэслэн нэмж, 8 дугаар сарын 17-ны өдрийн 04/51 дугаар тушаалаар 0.9 тэрбум төгрөгийг Төрийн банкны 106000057602 тоот хадгаламжийн гэрээний 3.9 дугаар заалтыг үндэслэн нэмж, 9 дүгээр сарын 18-ны өдрийн 04/62 дугаар тушаалаар 2.2 тэрбум төгрөгийг Улаанбаатар хотын банканд жилийн 13 хувийн хүүтэйгээр, хөрөнгө оруулалтад тус тус байршууллаа.

Гүйцэтгэх захирлын 8 дугаар сарын 17-ны өдрийн 04/51 дүгээр тушаалаар дунд түвшний эрсдэлээс хамгаалах сангийн хөрөнгө болох 301.7 сая төгрөг, хөрөнгө оруулалтын өгөөж болох 168.4 сая төгрөг, дээд түвшний эрсдэлээс хамгаалах сангийн хөрөнгө болох 429.9 сая төгрөг нийт 900.0 сая /есөн зуун сая/ төгрөгийг Төрийн банкны 106000057602 тоот хадгаламжийн гэрээний 3.9 дугаар заалтыг үндэслэн дээрх хадгаламжид нэмж байршуулсан.

Гүйцэтгэх захирлын 9 дүгээр сарын 18-ны өдрийн 04/62 дугаар тушаалаар Алдагдлаас хамгаалах сангийн 1.0 тэрбум төгрөг, дүрмийн сангийн 500.0 сая, хөрөнгө оруулалтын өгөөж болох 700.0 сая /долоон зуун сая/ төгрөгийг Улаанбаатар хотын банканд 1 жилийн хугацаатай жилийн 13 хувийн хүүтэйгээр байршууллаа.

Гүйцэтгэх захирлын 11 дүгээр сарын 01-ний өдрийн 04/79 дүгээр тушаалаар алдагдлаас хамгаалах сангийн 1.4 тэрбум, дүрмийн сангийн 3.6 тэрбум, хөрөнгө оруулалтын өгөөж болох 0.5 тэрбум нийт 5.5 тэрбум төгрөгийг Хаан банканд нэг жилийн хугацаатай, жилийн 13.6 хувийн хүүтэйгээр хөрөнгө оруулалтад байршууллаа.

Гүйцэтгэх захирлын 11 дүгээр сарын 05-ны өдрийн 04/80 дүгээр тушаалаар алдагдлаас хамгаалах сангийн 2.75 тэрбум, дүрмийн сангийн 6.1 тэрбум, хөрөнгө оруулалтын өгөөж 0.45 тэрбум нийт 9.3 тэрбум төгрөгийг жилийн 13.0 хувийн хүүтэй, Голомт банканд нэг жилийн хугацаатай байршуулж, мөн алдагдлаас хамгаалах сангийн 1.25 тэрбум, хөрөнгө оруулалтын өгөөж болох 0.75 тэрбум нийт 2.0 тэрбум төгрөгийг Хас банканд нэг жилийн хугацаатай, жилийн 12.5 хувийн хүүтэйгээр байршууллаа.

2018 онд Засгийн газрын үнэт цаасны өгөөж 323.7 сая, харилцах данснаас 47.4 сая, хадгаламжийн данснаас 6.1 тэрбум төгрөгийн хүүгийн орлогыг бүрдүүлж, нийт 6.5 тэрбум төгрөгийг төвлөрүүлэн, хөрөнгө оруулалтын багцыг өсгөн нэмэгдүүлж, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 51.1 хувиар давуулан биелүүлсэн байна.

2018 оны 1-4 үгээр улирлуудын хөрөнгө оруулалтын орлогын тайлан мэдээг бэлтгэж, удирдлагад танилцуулсан.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 02/06 дугаар тогтоолоор батлагдсан Хөрөнгө зохицуулах журмын 4.6-д заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн Эрсдэлийн хороонд Ажлын хэсэг өөрийн гаргасан судалгаа, дүгнэлтээ цаг алдалгүй цахим хэлбэрээр тогтмол хүргүүлэн ажилласан.

МИД-ын 2018 оны дүнд болон дээд түвшний эрсдэлээс хамгаалах сангийн хураамжийг төвлөрүүлэх ажлын хүрээнд:

МИД-ын дунд болон дээд түвшний эрсдэлээс хамгаалах санг бүрдүүлэх, байршуулах, зарцуулах, түүнд хяналт тавих журмын төслийг дахин шинэчилж Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлсэн бөгөөд Хууль зүйн яамнаас бүх дүрэм журмыг хянан баталдаг болсонтой холбоотойгоор хүлээгдсээр байна.

МИД-ын 2018 оны борлуулалтаар 3.46 тэрбум төгрөгийн хураамж төвлөрүүлж, Хамтын эрсдэлийн санд 1.56 тэрбум төгрөг, давхар даатгалын хураамжид 1.13 тэрбум төгрөгийг тус тус төвлөрүүлсэн ба 1.04 тэрбум төгрөгийг даатгагч нар үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна. Дунд түвшний эрсдэлээс хамгаалах сангийн хураамжийг нийт хураамжийн 5 хувиар буюу 173.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэхээр тооцоолсон. МИД-ын дээд түвшний эрсдэлээс хамгаалах сангийн хураамж болох 429.9 сая төгрөгийг 8 дугаар сарын 13-ны өдөр компанийн дансанд шилжүүлэн авсан.

Дүрмийн сан болон бусад сангийн мөнгөн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийж, орлого төвлөрүүлэх ажлын хүрээнд:

Банкнүүдтай байгуулсан хадгаламжийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж харилцах, хадгаламжийн хүү, өгөөжийн тооцооллыг сар бүр хийн компанийн нягтлан бодох бүртгэлийн дансанд бүртгэж, удирдлагад тухай бүрд нь танилцуулсан. Хугацааны эцэст орж ирэх хадгаламжийн хүүг нягтлан бодох бүртгэлд авлага хэлбэрээр бүртгэж байна. Давхар даатгагчийн алдагдлаас хамгаалах санг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журмын хавсралтыг улирал тутам гаргаж Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлээ.

5.2. Нөхөн төлбөрийн тооцоолол хийх, олголтын хүрээнд

2017-2018 оны МИД-ын нөхөн төлбөрийг олголтын ажлын хүрээнд:

Монгол Улсын Үндэсний Статистикийн хорооноос зохион байгуулсан 2018 оны хагас жилийн мал тооллогын дүнд үндэслэн 2017 оны МИД-ын нөхөн төлбөрийг хэмжээг тооцоолон 2017 онд малаа даатгуулсан **24,148** малчин өрхөөс Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дундговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Дархан-Уул, Орхон, Говьсүмбэр гэсэн 19 аймгийн нийт 130 сум болон Улаанбаатар хотын Налайх дүүргийн **8513** малчин өрхөд **1,091,975,096.95 /нэг тэрбум ерэн нэгэн сая есөн зуун далан таван мянга ерэн зургаан төгрөг ерэн таван мөнгө/** төгрөгийн нөхөн төлбөрийг олгоод байна.

Нийт нөхөн төлбөрийн 5.4 сая төгрөгийг дээд түвшний эрсдэлээс хамгаалах сангаас, бусад нөхөн төлбөрийг Хамтын эрсдэлийн сангийн болон түүний нөөц сангаас санхүүжүүллээ. Олон улсын давхар даатгалаас нөхөн төлбөр аваагүй.

Газар тариалангийн даатгалын нөхөн төлбөрийн тооцооллыг хийх, олгох ажлын хүрээнд:

Нэрлэсэн эрсдэлт улаан буудайн даатгалд хамрагдсан 11 аж ахуйн нэгжийн даатгуулсан талбайд Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК, Бодь даатгал ХХК, МИГ даатгал

ХХК болон Ард даатгал ХХК-ийн төлөөлөл бүхий хохирол үнэлгээний баг урьдчилсан болон бодит ургац тогтоолтын ажил хийсэн. Ургац тогтоолтын үр дүнд Төв аймгийн Сантын тариа ХХК, Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Их шинэстэй ХХК, Орхонтуул сумын Орхон хөгжил ХХК, Төв аймгийн Жаргалант сумын Алтан залаа ХХК, Угтаал сумын Элсэн цагаан ХХК гэсэн 5 аж ахуйн нэгжид нийт 590,619,259.04 /таван зуун ерэн сая зургаан зуун арван есөн мянга хоёр зуун тавин есөн төгрөг дөрвөн мөнгө/ сая төгрөгийн нөхөн төлбөр олгохоор тооцоолж, даатгагч нар болон СКОР /SCOR/ олон улсын давхар даатгалын компанитай хамтран нөхөн төлбөрийг бүрэн шилжүүлж дууслаа.

Эрчимжүүлсэн мал аж ахуйн даатгалын нөхөн төлбөрийг тооцоолох, олгох ажлын хүрээнд:

Эрчимжүүлсэн мал аж ахуйн даатгалын гэрээг Макс Агро ХХК, Бодь даатгал ХХК-уудтай байгуулснаас хойш нийт 31 эрсдэлийн дуудлага ирүүлснээс халтирч унасан 7, нүхэнд унасан 1 нийт 8 тохиолдолд нь гэрээнд заагдсан эрсдэл үүссэн гэж үзэж 14,512,500.00 /арван дөрвөн сая таван зуун арван хоёр мянга таван зуун/ төгрөгийн нөхөн төлбөрийг олголоо. Харин бусад тохиолдлуудад арчилгаа тордлогоо муу, халтирч унах нөхцөл үүссэн шалыг цэвэрлээгүй хийгдээгүй, дүрс бичлэг, баримт хангалттай бус зэрэг шалтгаануудаар нөхөн төлбөрийг тодорхойлох боломжгүй байгаа талаар Бодь даатгал ХХК-д мэдэгдээд байна.

Нөхөн төлбөрийн санхүүжилтийг хуваарилах, холбогдох сан, эх үүсвэрээс татах ажлын хүрээнд:

МИД-ын нөхөн төлбөрийн тооцооллын дагуу **1,086,574,545.42 /нэг тэрбум наян зургаан сая таван зуун далан дөрвөн мянга таван зуун дөчин таван төгрөг, дөчин хоёр мөнгө/** төгрөгийг Хамтын эрсдэлийн сангаас, **5,400,551.53 /таван сая дөрвөн зуун мянга таван зуун тавин нэгэн төгрөг, тавин гурван мөнгө/** төгрөгийг Дээд түвшний эрсдэлээс хамгаалах сангаас санхүүжүүллээ.

2017 оны борлуулалтын улиралд оролцсон даатгагч нар Хамтын эрсдэлийн санд 1,048,101,732.82 /нэг тэрбум дөчин найман сая нэг зуун нэг мянга долоон зуун гучин хоёр төгрөг, наян хоёр мөнгө/ төгрөгийн хураамж төвлөрүүлсэн бөгөөд үлдэгдэл 38,472,812.61 /гучин найман сая дөрвөн зуун далан хоёр мянга найман зуун арван хоёр төгрөг, жаран нэгэн мөнгө/ төгрөгийг Хамтын эрсдэлийн сангийн нөөц сангаас гаргасан. МИД-ын 2017 оны борлуулалтын орлогоос даатгагчид ашиг хүртээгүй болно.

НЭУБД-ын "Хувь оролцооны давхар даатгалын гэрээ"-ний дагуу нийт эрсдэлийн 15 хувь буюу 88.6 сая төгрөгийг Ард даатгал ХХК, Бодь даатгал ХХК, МИГ даатгал ХХК зэрэг даатгалын компани 3 даатгалын компани, 10 хувь буюу 59.1 сая төгрөгийг Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК, 75 хувь буюу 442.9 сая төгрөгийг СКОР /SCOR/ олон улсын давхар даатгалын компани тус тус хариуцах бөгөөд 442,964,444.28 төгрөгийг СКОР /SCOR/ олон улсын давхар даатгалын компаниас авч, 502,026,370.18 төгрөгийн нөхөн төлбөрийг даатгагчдад шилжүүлсэн.

5.3. Компани өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх талаар зах зээлийн судалгаа

Хөрөнгө оруулалтын орлогыг хэрхэн зөв зохистой хуваарилах, нөөц сангуудыг өсгөх боломжуудыг судалж "Хөрөнгө оруулалтын орлогын зохистой хуваарилалт" судалгааны ажил хийлээ. Компанийн хувьд өнгөрсөн хугацаанд хуримтлуулсан ашгийг хэрхэн хуваарилах нь ойрын хугацаанд шийдвэрлэх шаардлагатай асуудал бөгөөд нөөц сангуудыг өсгөх, шинэ бүтээгдэхүүний нөөц санг үүсгэх болон Үндэсний давхар даатгалын компани байгуулахад чиглүүлэн хөрөнгө хуримтлуулах гэсэн 3 шийдлийг тус судалгааны ажилд дэвшүүлсэн болно.

Мөн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх боломжийн судалгааг хийсэн. Өөрийн хөрөнгөө хуримтлагдсан ашгаар, хувьцаат капиталгаар, охин компани байгуулах, мөн нэгдэх замаар нэмэгдүүлэх боломжтой гэж үзсэн.

ЗУРГАА. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

6.1. Компанийн хүний нөөц, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн хамгааллын чиглэлээр:

Хүний нөөц, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн асуудал:

Компанийн ажилтнуудын хөдөлмөрийн гэрээний биелэлтийг эхний хагас жилийн байдлаар гаргуулан, газрын дарга нараар дүгнүүлсэн. Хөдөлмөрийн гэрээг 1 жилийн хугацаатай байгуулсан байсныг хугацаагүй болгон өөрчлөн бүх ажилтнуудын хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулав.

Компанийн бүтэц, орон тоог шинэчлэн батлагдсантай холбогдуулан ажилтнуудын зарим өөрчлөх шаардлагатай ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж Ерөнхий хуульчаар хянуулан, батлуулсан.

Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-ийн хүний нөөцийн хөгжлийг дэмжих бодлогын хүрээнд гадаадын их дээд сургууль, байгууллагууд руу ажилтнуудыг сургах, туршлага судлуулах боломжийг судлах зорилгоор Гадаад хэргийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яамны гадаад харилцаа, хүний нөөцийн асуудал хариуцсан холбогдох ажилтнуудтай холбогдож, тэтгэлэгт хөтөлбөрийн талаар мэдээлэл судлав. Үүний үр дүнд Сангийн яамнаас КОЙКА /БНСУ-ын олон улсын хамтын ажиллагааны байгууллага/-ын шугамаар БНСУ-ын Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрт хөдөө аж ахуйн эдийн засгийн чиглэлээр нэг ажилтныг сургахаар явуулсан ба Австрали Улсын Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрт нэг ажилтныг хамруулан сургахаар болсон.

Ажилтнуудын анкетыг шинэчлэн бүртгэсэн. Мөн ажилтнуудын хүүхдийн судалгаа, ажилласан жилийн судалгаа, авсан гавьяа шагнал, ээлжийн амралтын хуваарь зэргийг шинэчлэн гаргав.

Олон нийтийг хамарсан ажлын хүрээнд:

Компанийн 2018 оны дотоод олон нийтийн ажлын төлөвлөгөөг гарган батлуулсан. Төлөвлөгөөний дагуу дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

- Гандантэгчилэн хийдэд 2018 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн билигт сайн өдөр байгууллагын эд хөрөнгө арвижих, ажил үйлс бүтээх, ажилтнуудын эрүүл мэндийг даатгах ном уншуулсан.
- Цагаан сарын золголтын арга хэмжээг 2018 оны 02 дугаар сарын 19-ний өдөр /шинийн 5-ны өдөр/ оффисын байрандаа зохион байгуулсан.
- Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монголын Ардын армийн баярыг хамт олныхоо хүрээнд тэмдэглэн өнгөрүүлэв.
- Компанийн ажилтнуудаа эрүүл мэндийн даатгалд хамруулах зорилгоор Бодь даатгал ХХК, Ард даатгал ХХК, Монгол даатгал ХХК-уудын даатгалын мэргэжилтэн болон эрүүл мэндийн ажилтнуудыг зохион явуулсан сургалтад хамруулж, эрүүл мэндийн даатгалын талаар цогц мэдээллийг өгсөн. 2018 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн ажилтнуудыг Бодь даатгал ХХК-ийн эрүүл мэндийн даатгалд хамруулах гэрээ байгуулан хэрэгжүүлэн ажиллаж байна.
- Дорноговь аймгийн Хамрын хийд, Хүслийн хар ууланд 2018 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр хамт олноороо очиж ажил үйлсээ даатган аялаад ирлээ.
- “Кёкюшүзан” спорт цогцолбортой нэг жилийн хугацаатай гэрээ байгуулан Мягмар гараг бүрийн 17:00 цагаас 2 цагийн турш спортоор хичээллэж байна.

- Гүйцэтгэх захирлын 2018 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн 04/45 дугаар тушаалын дагуу 2018 оны эхний хагас жилийн ажлын үзүүлэлтээр газар нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөөг 92.9-95.7 хувиар биелүүлсэн Бизнес хөгжил, төслийн газар, Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газрын ажилтнууд Архангай, Завхан, Увс аймгийн байгалийн үзэсгэлэнт газруудаар 2018 оны 7 дугаар сарын 19-ний өдрөөс 29-ний өдрүүдэд танин мэдэхүйн аялалд хамрагдсан. Архангай болон Увс аймагт аялах хугацаандаа орон нутаг дахь МИД-ын төлөөлөгч нартай уулзалт хийж гарын авлага, тараах материалаа өгсөн.
- Даатгагчдын холбооноос жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг спортын өдөрлөгт хамт олноороо ажилттай оролцсон. Сагсны төрөлд эмэгтэй баг алтан медаль, эрэгтэй баг мөнгөн медаль, шатрын төрөлд эмэгтэй хүрэл медаль тус тус хүртсэн. Медальт байранд шалгарсан тамирчдад компанийн зүгээс мөнгөн шагнал олгов.
- Мөн 2018 оны 11 дүгээр сарын 21-ний өдрөөс 25-ны өдрүүдэд зохиогдсон Сангийн яамны харьяа байгууллагуудын дундах спортын наадамд хамт олноороо амжилттай оролцсон.
- Хүүхдийн баяр, Шинэ жилийн баярыг тохиолдуулан компанийн ажилтнуудын хүүхдүүдэд бэлэг өгөв.
- Гачигдал тохиолдсон 5 ажилтанд, шинэ хүүхдээ хүлээн авсан 2 ажилтанд компанийн нийт ажилтнуудаас сэтгэлийн хандив өглөө. Мөн эмнэлэгт хэвтсэн, хагалгаанд орсон, гадагшаа сургуульд явсан ажилтнууддаа сэтгэлийн хандивыг тухай бүрд нь цуглуулж өгсөн.

Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд:

- Хамт олноороо 2 дахь жилдээ 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр цусны төвд сайн дураараа цусаа хандивлалаа.
- Увс аймгийн Ховд сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдардаг малчдын хүүхдүүдийн амьдрах орчныг сайжруулахад зориулж компанийн ажилтнууд сайн дурын үндсэн дээр нэг өдрийн цалин буюу 1,702,000.00 /нэг сая долоон зуун хоёр мянган/ төгрөгийг хандивлалаа.
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар жил бүрийн 5, 10 дугаар сарын хоёр дахь долоо хоногийн Бямба гарагийг “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр” хэмээн зарласантай холбогдуулан манай компанийн хамт олон 2018 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд тусгайлан бэлдсэн талбайд 10 бут улиас мод тарьж суулгасан. Цаашид жил бүр суулгасан модоо очиж арчлан хамгаалж байхаар боллоо.

Ажилтнуудыг дотоод сургалтад хамруулах ажлын хүрээнд:

Компанийн 2018 оны дотоод сургалтын төлөвлөгөөг гарган батлуулсан. Төлөвлөгөөний дагуу мэргэжил арга зүйн чиглэлээр чадавхжуулах сургалтуудад ажилтнуудаа тогтмол хамруулж байна. Үүнд:

- 2018 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр Дэд захирал, Захиргаа, удирдлагын газрын дарга, Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газрын дарга нар ажилтнуудад компанийн Бизнес төлөвлөгөө, Газар нэгжийн чиг үүргийн талаар мэдээлэл өгч, дотоод ажлын талаар санал солилцов.
- Компанийн ажилтнуудаа эрүүл мэндийн даатгалд хамруулах зорилгоор Бодь даатгал ХХК, Ард даатгал ХХК, Монгол даатгал ХХК-уудын даатгалын мэргэжилтэн болон эрүүл мэндийн ажилтнуудыг урьж авч ирэн сургалт хийж, эрүүл мэндийн даатгалын талаар цогц мэдээллийг өгсөн.
- 2018 оны 5 дугаар сарын 16-ны өдөр Бизнес хөгжил, төслийн газрын Гадаад хамтын ажиллагааны ажилтан Г.Нямдаваа “Худалдааны зээлийн даатгалын бүтээгдэхүүний үйлчилгээ” сэдвээр;

- 2018 оны 6 дугаар сарын 12-ны өдөр Захиргаа, удирдлагын газрын Нягтлан бодогч Ю.Отгон “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай дотооддоо баримтлах журмыг танилцуулах” сэдвээр;
- 2018 оны 6 дугаар сарын 26-ны өдөр Андеррайтингийн газрын Даатгалын шинжээч О.Сарантуяа “Монгол улс дахь эрчимжүүлсэн мал аж ахуйн хөгжил” сэдвээр;
- 2018 оны 6 дугаар сарын 27-ны өдөр Бизнес хөгжил, төслийн газрын Гадаад хамтын ажиллагааны ажилтан Г.Нямдаваа, Эрсдэлийн шинжээч Б.Гантуяа нар “Эрчимжүүлсэн мал аж ахуйн даатгалын талаар танилцуулга” сэдвээр;
- 2018 оны 10 дугаар сарын 04-ний өдөр Нийслэлийн онцгой байдлын газрын гал түймэртэй тэмцэх хэлтсийн төрийн ордны гамшгаас хамгаалах тасгийн гал түймрийн улсын хяналтын байцаагч, Ахлах дэслэгч С.Буян-Арвижих, Нийслэлийн онцгой байдлын газрын гал түймэртэй тэмцэх хэлтсийн төрийн ордны гамшгаас хамгаалах тасгийн аврагч, Ахлах ахлагч Х.Бат-Энх нар “Ажлын байрны аюулгүй байдал, галын аюулгүй байдал” сэдвээр;
- 2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр компанийн удирдлагууд компанийн ажилтнуудыг үйл ажиллагааны мэдээллээр хангах, Хөдөлмөрийн дотоод журмын өөрчлөлт, компанийн нэр өөрчлөгдсөнтэй холбоотой лого, брэндбүүк зэрэг асуудлаар санал солилцох сургалтыг, Ерөнхий хуульч Г.Батзаяа “Авлигатай тэмцэх, хэрхэн сэргийлэх” талаар сургалтыг, нягтлан бодогч Ю.Отгон “Авто машин ашиглалтын журам”-ыг танилцуулах сургалтыг;
- 2018 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр Ерөнхий хуульч Г.Батзаяа “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалтыг тус тус зохион байгуулсан.
- 2018 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр компанийн нийт ажилтнуудад албан хэрэг хөтлөлтийн стандарт, архив, бичиг хэрэгтэй холбоотой мэдлэг олгох сургалтыг сургагч багш урин зохион байгуулсан.
- Өдөр бүр 12.30 цагаас хэлний мэдлэгээ дээшлүүлэх сонирхолтой ажилчид хурлын өрөөнд англи хэлний Тоефлын үг цээжлэх, орчуулга хийх зэргээр өөрсдийгөө хөгжүүлж байна.
- Ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөвлөгөө өгөх хүрээнд Ёс зүйн хорооны дарга, хуульч Г.Батзаяа төрийн албан хаагчийн ёс зүйн талаар компанийн нийт ажилчдад сургалт, мэдээлэл хийв.
- Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх ажлын хүрээнд Ёс зүйн хорооны дарга, хуульч Г.Батзаяа компанийн нийт ажилчдад авлигын эсрэг хуулийн талаар танилцуулга, авлигаас урьдчилан сэргийлэх сургалт мэдээллийг хийв.

Мөн компанийн нийт ажилтнуудыг мэргэжлийн дагуу Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Авлигатай тэмцэх газар болон бусад холбогдох газруудаас зохиогдсон бүхий л сургалтад хамруулсан.

6.2. Компанийн санхүүгийн үйл ажиллагаа

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилтийг ханган ажиллах ажлын хүрээнд:

2018 оны төсвийн төсөл дээр санал боловсруулан өөрчлөлт оруулан бэлтгэж, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 02/01 дүгээр тогтоолоор батлуулсан.

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой хууль, журмыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаж байна. 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр байсан Хувь хүний орлогын албан татвар /ХХОАТ/-ын тухай хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу цалин тооцоог хийсэн. Гэвч ХХОАТ-ын тухай хуульд дахин өөрчлөлт орсноор ажилтнуудаас суутган авсан суутгалын зөрүү болон татварын зөрүүг 1 дүгээр улиралдаа багтаан залруулсан.

Нягтлан бодох бүртгэлийн өдөр тутмын гүйлгээг “Юникус” санхүүгийн программ хангамжийг ашиглан хийж байгаа бөгөөд анхан шатны баримтууд буюу ажил гүйлгээ гарсныг нотлох бусад баримтуудыг хянаж баримтжуулан бүртгэлд тусгаж байна.

Хөдөлмөрийн гэрээнд заасан үндсэн цалингийн дагуу сар бүрийн 05-ны өдөр эхний хэсгийг /урьдчилгаа цалин/, 20-ны өдөр цагийн бүртгэлийг үндэслэн цалингийн үлдсэн хэсгийг олгож байна.

Компанийн Нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу компанийн бэлэн мөнгө буюу кассын үйл ажиллагааг нягтлан бодогчоос салган шинээр бий болсон орон тооны ажилтанд хариуцуулан хүлээлгэн өгсөн. Компанийн хувьд эд хогшил хөрөнгө, бэлэн мөнгө зэргийг туслах нягтлан бодогч хариуцдаг байсныг өөрчилсөн.

Санхүүгийн программыг шинэчлэн хандалтын 2 түвшинтэй болгов. 1 дүгээр түвшний хандах эрх дээр Ерөнхий нягтлан бодогч ажиллах эрхтэй бөгөөд засварлах, хаалт хийх, тайлан бэлтгэх, санхүүгийн давхар бичилтүүдийг хийж тааруулах зэрэг түвшинд ажиллаж байна. 2 дугаар түвшний хандах эрхээр Нягтлан бодогч, Захиргаа, аж ахуй хариуцсан ажилтан нар ажиллах бөгөөд зөвхөн харилцах дансны хуулга боловсруулах, дараа тооцоо болон урьдчилж гарсан данснуудын хаалтын бичилтийг зөвхөн тухайн сардаа хийж гүйцэтгэх үүрэгтэй болсон. Мөн өмнөх сар болон улирлын дансны бичилтүүдийг зөвхөн харах эрхтэй бөгөөд засварлах, устгах боломжгүй болсон. Ингэснээрээ компанийн Нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн үнэн зөв бүртгэл хөтлөлт, зөв тайлагналын эхлэл болсноороо үр дүнтэй ажил боллоо.

Жил, улирлын санхүүгийн тайланг гаргах, гүйцэтгэх удирдлагыг санхүүгийн мэдээллээр хангах ажлын хүрээнд:

Компанийн шинээр борлуулсан бүтээгдэхүүнд тааруулан Санхүүгийн программ хангамждаа даатгалын тайлагналын тохируулгуудыг хийж өгснөөр нэмэлт тайлангууд, нөөцийн сангийн бодолт зэрэг мэдээллүүд нь үнэн зөв тайлагнагдаж байна. Тус компанийн программ хангамж нь бизнесийн байгууллагад зориулан хийгдсэн бөгөөд үүнийг даатгалын бүртгэлийн онцлогт тохируулан тухай бүрд нь тохируулга хийн ашиглаж байна.

2017 оны Санхүүгийн тайланг бэлтгэн олон улсын Эрнест энд Янг Монголиа Аудит ХХК /Ernst & Young Mongolia Audit/-аар аудит хийлгэж, хуулийн хугацаанд Сангийн яам болон Санхүүгийн зохицуулах хороо мөн харьяа Татварын байгууллагуудад хүргүүлэв. Мөн аудитлагдсан Санхүүгийн тайланг Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулсан. Компанийн хувьцаа эзэмшигч буюу Сангийн сайдын 2018 оны 61 дүгээр тушаалаар компанийн 2017 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг дүгнэж, баталгаажуулав.

Улирал бүрийн Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд нь Санхүүгийн зохицуулах хороо болон харьяа Татварын байгууллагад хүргүүлсэн. Нийгмийн даатгалын тайланг сар бүрийн 10-ны өдрийн дотор бэлтгэн нийгмийн даатгалын байцаагчид тушаадаг. Ажилтан тус бүрийн нийгмийн даатгалын дэвтэр дээр бичилт хийгдэн баталгаажсан.

Батлагдсан санхүүгийн төлөвлөгөөг орлого болон зардлын төрөл, зүйл, бүлэг бүрээр сар бүрд хуваарилан Гүйцэтгэх захирлаар батлуулсан ба улирал бүр төсвийн гүйцэтгэлийг гарган удирдлагад танилцуулж байна. Гүйцэтгэх удирдлагад цаг тухай бүрд нь санхүүгийн мэдээллийг танилцуулж байна.

6.3. Компанийн худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлэх чиглэлээр:

Компанийн худалдан авалтын үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хүрээнд:

Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу оффисын байрны түрээсийн үйлчилгээ үзүүлэгчийг сонгон шалгаруулалтыг 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдөр зарласан. 2018 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр нээж шаардлага хангасан үнийн санал ирүүлсэн Сэрүүлэг Констракшн ХХК-ийг шалгаруулж гэрээ байгууллаа.

Компанийн сурталчилгааны Хуанли хэвлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтыг Гүйцэтгэх захирлын 2018 оны 04/02 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг харьцуулалтын аргаар зохион байгуулсан. Сонгон шалгаруулалтыг 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр зарласан бөгөөд 01 дүгээр сарын 17-ны өдөр нээж үнэлсэн. Мөнхийн үсэг ХХК, Бэстколор интернэшнл ХХК, Эс Пи Ар ХХК зэрэг 3 аж ахуйн нэгж үнийн саналаа ирүүлснээс техникийн тодорхойлолтын шаардлага хангасан, хамгийн бага үнийн санал ирүүлсэн Эс Пи Ар ХХК-ийг шалгаруулж, 10.0 мянган ширхэг хуанлийг хэвлүүлэх гэрээ байгуулан хэрэгжүүлэв.

Компанийн 2017 оны санхүүгийн тайланд аудитын үйлчилгээ үзүүлэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журмын дагуу 2018 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр зарласан ба Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны 2018 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01 тоот шийдвэрээр Эрнст энд Янг Монголия Аудит ХХК-ийг шалгаруулан хэрэгжүүлсэн.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу Суудлын машин худалдан авах ХААДДХК/201804006 дугаартай нээлттэй тендер шалгаруулалтыг 2018 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр зарлаж амжилттай зохион байгууллаа. Худалдан авах үйл ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон ажиллаж байна.

Компанийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийлгэх зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ХААДДХК/201804001 дугаартай тендерийг 2018 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр зарлаж, одоогийн байдлаар оролцох хүсэлтэй байгаа зөвлөхийн саналыг хүлээн авч байна.

2018 оны санхүүгийн тайланд аудит хийлгэх зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ХААДДХК/201804001 дугаартай тендерийг зарлаж, зөвлөхийн зарлалыг 2018 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр зарласан. Зөвлөх сонгох үйл ажиллагаа тус хууль журмын дагуу явагдаж Эрнст Энд Янг Монголия Аудит ХХК шалгарсан бөгөөд 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр гэрээ байгуулагдан ажиллаж байна.

Мөн компанийн үйл ажиллагаанд зориулж сервер компьютер худалдан авах үйл ажиллагааг хуулийн дагуу харьцуулалтын аргаар явуулж хамгийн сайн гэж үнэлэгдсэн Саммит компьютер технологи ХХК-тай гэрээ байгуулж худалдан авалт хийгдсэн.

Засгийн газрын худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтыг холбогдох байгууллагаас 2018 оны 10 дугаар сарын 11-ний өдрөөс 13-ны өдрүүдэд зохион байгуулсан ба 10 ажилтан хамрагдаж бүгд шалгалтдаа тэнцэж АЗ сертификат авлаа.

Бичиг хэрэг болон цэвэрлэгээний шаардагдах материалыг батлагдсан төсвийн дагуу чанар байдал, үнэ зэргийг харгалзан захиалах, худалдан авч нөөцлөх, авсан материал

бүрд холбогдох баримт гаргуулж авч баримтжуулж байна. Материалыг шаардлагатай байгаа тухай бүрд нь олгож байна.

Монгол Улсын Засгийн газрын www.shilendans.mn сайтад худалдан авалт болон нягтлан бодох бүртгэлтэй холбоотой бусад мэдээллийг цаг тухай бүрд нь мэдээлж байгаа болно.

Ажлын байр, техник хэрэгсэл, эд зүйлийн хангамж, бүртгэл, хадгалалт, хамгаалалтыг сайжруулан зохион байгуулах ажлын хүрээнд:

Компанийн болон газар нэгжийн өдөр тутмын болон цаг үеийн бусад ажлыг хэвийн явуулахад шаардлагатай дотоод ажлыг шуурхай зохион байгуулан ажиллаж байна. Оффисын байрны эмх цэгц, зохион байгуулалттай холбоотойгоор санхүүгийн өрөөнд шинэ хаалга суурилуулах, үүдний хаалганы түгжээг солиулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Бичиг хэрэг болон цэвэрлэгээний шаардагдах материалыг батлагдсан төсвийн дагуу чанар байдал, үнэ зэргийг харгалзан захиалах, худалдан авч нөөцлөх, авсан материал бүрд холбогдох баримт гаргуулж авч баримтжуулж байна. Материалыг шаардлагатай байгаа тухай бүрд нь олгож байна.

Компанийн ажилтнууд өдрийн цайгаа хийх зориулалтаар гал тогооны хэсэгт тавилга болон тавцан плитк суурилуулж өгсөн. Мөн гал тогооны хэсэгт нэмэлтээр 2 ширхэг ханын залгуур /розетка/ суурилуулж өгснөөр ачаалал багасаж аюулгүй ажиллагаа сайжирсан. Түүнчлэн 2018 оны МИД-ын борлуулалтын гэрээт баталгааны 160 орчим үдэж архивласан баримтуудыг агуулахын өрөөнд ус чийг галын аюулаас хамгаалан хадгалсан.

Эд хөрөнгийн тооллогыг 2018 онд 2 удаа явуулсан. 3 дугаар сард хөрөнгийн тооллогыг эд хариуцагч солигдсонтой холбоотойгоор хийсэн бөгөөд жилийн эцсийн санхүүгийн тайланд баталгаажуулалт болгохоор комисс байгуулан 2 дахь тооллогыг хийж байна.

Мөн компанийн 64-89 УБР автомашины элэгдлийн залруулга болох 17.3 сая төгрөгийн зардлыг нэмж байгуулан бүртгэлийг залруулсан болно.

6.4. Компанийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах талаар:

2018 онд нийт 96 Гүйцэтгэх захирлын тушаал, 251 албан бичгийг удирдлагууд, газрын дарга, ерөнхий хуульчаар хянагдаж гарын үсэг зурагдсаны дараа албан тоот дээр бичиг хэргийн шаардлага, стандартын дагуу хэвлэн гаргасан. Мөн гаднаас ирсэн 95 албан бичгийн танилцуулах хуудсаар удирдлагын цохолт хийлгэж, хариутай бичгийн бүртгэл, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа.

Тайлант хугацаанд ажилтнуудаас 8 өргөдөл, хүсэлт ирснээс 7 өргөдлийг нь бүрэн шийдвэрлэв.

Гүйцэтгэх захирлын тушаалыг бүртгэн авч, шийдвэрлэлтийн мэдээг хугацаанд нь гарган тайлагнаж, удирдлагуудыг холбогдох мэдээллээр ханган ажиллалаа. Хэвлэмэл хуудасны захиалга, ашиглалтыг хянаж ажиллаж байна. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулж, батлуулан мөрдөж ажилласан.

Ирсэн, явсан бичиг, Гүйцэтгэх захирлын тушаал зэрэг үндсэн бичгийн хөтлөлт журмын дагуу хөтлөгдөж байна. Мөн бүх ирсэн, явсан бичиг, Гүйцэтгэх захирлын тушаалыг цахим бүртгэлд давхар бүртгэж байна.

Ажилтан бүрийн 4 улирлын хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлтийг гаргуулан газар нэгжээр нэгтгэн, газрын дарга нараар хянуулан баталгаажуулсан. Газар

нэгжийн ирүүлсэн төлөвлөгөөний биелэлт, тайланг нэгтгэн компанийн 2018 оны ажлын төлөвлөгөөний биелэлт, бичмэл тайланг гаргасан.

Компанийн нэр дээр бүртгэлтэй авто машинуудын засвар үйлчилгээг цаг тухайд нь хийлгэсэн ба авто машины татвар хураамжууд бүрэн төлөгдсөн.

Авто машин ашиглалтын журмыг боловсруулан удирдлагаар батлуулсан ба Гүйцэтгэх захирлын 04/70 дугаар тушаалын дагуу уг журмыг компанийн жолооч болон холбогдох албан хаагчдад танилцуулан 2018 оны 10 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлэн ажиллаж байна.

Компанийн бүртгэлд байгаа автомашинуудад хийгдсэн засвар үйлчилгээг тухай бүрд нь бүртгэж байх зорилгоор машин тус бүрийг техник ашиглалтын паспорттой болгосон. Ингэснээр тухайн машин хэзээ, хаана, ямар засвар үйлчилгээг ямар дүнгээр авсныг тодорхой харж болохоор болсон.

Сүүлийн саруудын шатахууны үнийн статистик мэдээллийг үндэслэн томилолтоор явахад мөрдөх шатахууны үнийг бүсчлэн гаргаж мөрдүүлж байна.

6.5. Хуулийн хэрэгжилт, дотоод хяналт, Төлөөлөн удирдах зөвлөлийн дотоод ажил

Компанийн 2018 оны авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Гүйцэтгэх захирлаар батлуулан Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн бөгөөд хэрэгжүүлэн ажиллаж байна.

2017 оны тайлант хугацаанд нийт 12 хүн мэдүүлэг гаргахаар бүртгэлтэй байсан ба бүгд хуулийн хугацаанд мэдүүлгийг бүрэн гаргаж тайлагнав.

“Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийн хүрээ”-нд АТГ-аас зохион байгуулсан нийтийн албан тушаалтнуудад зориулсан сургалтад ерөнхий хуульч, Захиргаа, удирдлагын газрын дарга, захиргаа, аж ахуй хариуцсан ажилтан, нягтлан бодогч, дотоод хяналтын ажилтан нар хамрагдлаа.

МИД-ын оролцогч даатгалын компаниудтай МИД-ын алдагдал зогсоох давхар даатгалын гэрээний загвар болон бусад төр, хувийн хэвшлийн байгууллагуудтай байгуулах гэрээний загвар, дотоод үйл ажиллагааны дүрэм, журмын төсөл зэргийг хууль эрх зүйн хүрээнд хянан боловсруулж батлуулсан.

Мөн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, Гүйцэтгэх захирлын тушаал, гадагшаа явуулж байгаа албан бичгийн төслийг хянах, засварлах зэргээр компанийн үйл ажиллагааны эрх зүйн үндэслэлийг ханган ажиллалаа.

Компанийн гүйцэтгэх захирлын 2017 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 04/35 дугаар тушаалаар Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэн ажилласан. Хөтөлбөрийн дагуу компанийн хэмжээнд дагаж мөрдөх “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх, түүнтэй тэмцэхэд харилцагчийг таньж мэдэх талаар дотооддоо баримтлах журам”-ыг батлуулсан.

Мөн төлөвлөгөөнд тусгасны дагуу 2018 оны 6 дугаар сарын 12-ны өдөр компанийн нийт ажилтнуудын дунд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх талаар, харилцагч байгууллагууд болон хувь хүн иргэнийг таньж мэдэх талаар сургалтыг зохион байгуулсан. Энэхүү сургалтын зорилго нь даатгалын зах зээлийн хөгжил, сайн засаглалыг дэмжих, санхүүгийн тогтолцоог илүү тод болгох, харилцагчийн шударга бизнесийг дэмжих, залилан мэхэлж хөрөнгө мөнгө завших зэрэг санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэж, урьдчилан сэргийлэн компанийн нэр хүндийг хамгаалах

зорилготой батлагдсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх, түүнтэй тэмцэхэд харилцагчийг таньж мэдэх талаар дотооддоо баримтлах журам”-ын талаар дэлгэрэнгүй мэдээллийг ажилтнуудад хүргэх юм.

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн хүрээнд олон улсын нэр хүнд бүхий Эрнст энд Янг Монголия Аудит ХХК нь компанийн 2017 оны санхүү болон үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын зөвлөмжийн дагуу илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж ажиллалаа.

Компанийн санхүүгийн холбогдолтой үйл ажиллагаанд хийсэн дотоод хяналт шалгалтын ажлын хүрээнд илэрсэн зөрчил дутагдлыг арилгах зөвлөмж өгөн ажилласан.

Гүйцэтгэх захирлын тушаалаар хийж гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлд дотоод хяналт шалгалтыг тухай бүр нь хийсэн. Компанийн төсөв, хөрөнгө оруулалт, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг хийж Аудитын хорооны дарга, гишүүдэд тухай бүр нь тайлагнасан.

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд заасны дагуу Малын индексжүүлсэн даатгалын босго үзүүлэлтийг шинэчлэн батлуулахаар бэлтгэл ажлыг хангаж, тогтоолын төслийг бэлтгэн Засгийн газрын хуралдаанаар батлуулав.

Компанийн хувьцаа эзэмшигчийн шийдвэр буюу Сангийн сайдын 2018 оны 61 дүгээр тушаалаар компанийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталж, Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгууллаа.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал 2018 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хуралдаж компанийн 2018-2020 стратеги төлөвлөгөө, 2018 оны бизнес төлөвлөгөө, санхүүгийн төлөвлөгөө, худалдан авалтын ерөнхий төлөвлөгөөг баталсан. Мөн тус хурлаар Тариалангийн даатгалын тухай танилцуулагдсан.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн ээлжит хуралдаанаар Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг түр томилох, хараат бус гишүүний сонгон шалгаруулалтыг зарлах, гишүүдийг хороодод томилох тухай шийдвэр гарсан болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал 2018 оны 8 дугаар сарын 21-ний өдөр хуралдаж, Малын индексжүүлсэн даатгалын бүтээгдэхүүний давхар даатгагчийг сонгож гэрээ байгуулах зөвшөөрлийг олгов. Мөн энэ хурлаар малын индексжүүлсэн даатгалын 2017-2018 оны нөхөн төлбөрийг олгох тухай шийдвэрийг гаргасан.

Мөн Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хууль болон журамд нийцүүлэн зохион байгуулах ажлын бэлтгэлийг хангаж, хурлын шийдвэр гаргахад шаардлага бүхий мэдээлэл, баримтыг бэлтгэх ажлыг хийж гүйцэтгэлээ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар 2019 оны санхүүгийн төлөвлөгөө, Худалдан авалтын Ерөнхий төлөвлөгөөг батлах тухай, МИД-ын гэрээний загвар батлах тухай, Компанийн бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай, Албан тушаалын ангилал, зэрэглэл, шатлалын журам батлах тухай асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэв.

ДОЛОО. ДҮГНЭЛТ

Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК нь өнгөрсөн хугацаанд давхар даатгалын тогтолцоог нэвтрүүлж, бүтээгдэхүүн үйл ажиллагааныхаа цар хүрээг тэлж, дотоодын 11 даатгагч, даатгалын зуучлагч болон 10 гаруй банк санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллаж, нийтдээ давхардсан тоогоор **53,203** малчин өрх, 11 газар тариалан эрхлэгч ААН-ийг даатгаж, байгаль цаг уурын болзошгүй эрсдэлээс хамгаалж чадсан бол гадаад харилцааг хөгжүүлэх чиглэлээр 20 гаруй олон улсын давхар даатгагч болон экспортын зээлийн даатгагч, олон улсын мэргэжлийн холбоод, банк, санхүүгийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн ажиллалаа.

Тайлант онд МИД-ын борлуулалтын орлогын төлөвлөгөөг 173.1 хувийн гүйцэтгэлээр давуулан биелүүлж 3,462,697,746.80 /гурван тэрбум дөрвөн зуун жаран хоёр сая зургаан зуун ерэн долоон мянга долоон зуун дөчин зургаан төгрөг, наян мөнгө/ төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлэв.

Нэрлэсэн эрсдэлт улаан буудайн даатгалд таваарын болон үрийн 11 аж ахуйн нэгж байгууллагыг даатган давхар даатгалын хураамжид 115,667,227.51 /нэг зуун арван таван сая зургаан зуун жаран долоон мянга хоёр зуун хорин долоон төгрөг тавин нэгэн мөнгө/ төгрөгийг төвлөрүүллээ.

Мөн газар тариалангийн хүнд машин, механизмийн тоног төхөөрөмжийн даатгалд **120** аж ахуйн нэгж, иргэнийг хамруулсан ба эрчимжүүлсэн мал аж ахуйн даатгалд Сэлэнгэ аймгийн Мандал суманд байрлах Макс Агро ХХК-ийн саалийн үнээний фермийн саалийн үнээ, бяруу, тугал зэрэг нийт 411 үхрийг даатгалд хамрууллаа.

Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-ийн оноосон нэрийг 2018 онд Үндэсний давхар даатгалын компани болгон өөрчлөхөөр судалгаа шинжилгээ хийн мэдээллийг нэгтгэн Сангийн яам, Засгийн газарт танилцуулахад бэлдэн ажиллалаа. Монгол Улсын Засгийн газрын 10 дугаар сарын 10-ны өдрийн хуралдааны 303 дугаар тушаалаар Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-ийн нэрийг Үндэсний давхар даатгалын компани болгон өөрчилсөн. Ингэснээр хөдөө аж ахуйн болон бусад чиглэлд давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх боломжтой болж байна. Үндэсний давхар даатгалын компани болсноор давхар даатгалын хураамжийн гадагшлах урсгалыг бууруулах, даатгалын компаниудтай хамтран ажиллаж томоохон эрсдэлийг хамтын хүчээр дотооддоо даатгах боломжийг бүрдүүлж байгаа юм.

“Хөрөнгө зохицуулах журам”-ын дагуу байгуулагдсан ажлын хэсэг 2018 онд нийт 18 удаа хуралдаж, хөрөнгө оруулалтын өгөөжөөс 4.1 тэрбум, улсын төсвөөс бүрдүүлдэг дээд түвшний эрсдэлээс хамгаалах сангийн 0.4 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтын багцад нэмж нийт 45.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын багцыг бүрдүүлэн ажиллалаа.

Тайлант онд Засгийн газрын үнэт цаасны өгөөж 323.7 сая, харилцах данснаас 47.4 сая, хадгаламжийн данснаас 6.1 тэрбум төгрөгийн хүүгийн орлогыг бүрдүүлж, нийт 6.5 тэрбум төгрөгийн хүүгийн орлого бүрдүүлж, орлогынхоо 24.4 хувийг урсгал зардалд, 20.7 хувийг даатгалын зардалд зарцуулсан байна.

2018 онд 4.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын орлого, 1.4 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамжийн орлого олохоор төсөвлөсөн бөгөөд тайлант оны эцсийн байдлаар хөрөнгө оруулалтын орлого 51.1 хувиар, давхар даатгалын орлого 21.4 хувиар төлөвлөгөөгөө тус тус давуулан биелүүлэв.

МИД-ын 2018 оны борлуулалтаар 3.46 тэрбум төгрөгийн хураамж төвлөрүүлж, хамтын эрсдэлийн санд 1.56 тэрбум төгрөг, давхар даатгалын хураамжид 1.13 тэрбум

төгрөгийг тус тус төвлөрүүлсэн ба 1.04 тэрбум төгрөгийг **даатгагч нар** үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна.

МИД-ын 2017 оны нөхөн төлбөрт 19 аймгийн нийт 130 сум болон Улаанбаатар хотын Налайх дүүргийн 8513 малчин өрхөд 1,091,975,096.95 /нэг тэрбум ерэн нэгэн сая есөн зуун далан таван мянга ерэн зургаан төгрөг, ерэн таван мөнгө/ төгрөгийн төлбөрийг олгоод байна.

Нөхөн төлбөр олгогдсонтой холбоотойгоор малчны аймаг сумын бүртгэлийг буруу бүртгэсний улмаас малчинд нөхөн төлбөр олгогдохгүй байх асуудал гарсан. Иймд 2018 оны МИД-д даатгуулсан малчдын мэдээллийг тулган алдааг засан ажиллалаа. Мөн нөхөн төлбөрөө авч чадаагүй малчдын хохирлыг барагдуулах ажлыг хийж байна.

Нэрлэсэн эрсдэлт улаан буудайн даатгалд хамрагдсан 11 аж ахуйн нэгжийн даатгуулсан талбайд Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК, Бодь даатгал ХХК, МИГ даатгал ХХК болон Ард даатгал ХХК-ийн төлөөлөл бүхий хохирол үнэлгээний баг ажиллаж 5 аж ахуйн нэгжид нийт 590,619,259.04 /таван зуун ерэн сая зургаан зуун арван есөн мянга хоёр зуун тавин есөн төгрөг, дөрвөн мөнгө/ төгрөгийн нөхөн төлбөр олгохоор тооцоолж, даатгагч нар болон СКОР /SCOR/ олон улсын давхар даатгалын компанитай хамтран нөхөн төлбөрийг бүрэн шилжүүлж дууслаа.

Эрчимжүүлсэн мал аж ахуйн даатгалын гэрээг Макс Агро ХХК, Бодь даатгал ХХК-уудтай байгуулснаас хойш нийт 31 эрсдэлийн дуудлага ирүүлснээс 8 тохиолдолд нь гэрээнд заагдсан эрсдэл үүссэн гэж үзэж 14,512,500.00 /арван дөрвөн сая таван зуун арван хоёр мянга таван зуун/ төгрөгийн нөхөн төлбөрийг олголоо.

Судалгааны ажлын хүрээнд хөрөнгө оруулалтын орлогыг хэрхэн зөв зохистой хуваарилах, нөөц сангуудыг өсгөх боломжуудыг судалж “Хөрөнгө оруулалтын орлогын зохистой хуваарилалт”, “Өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх боломжууд” гэсэн судалгааны ажлууд хийлээ.

Санхүүгийн программыг шинэчлэн хандалтын 2 түвшинтэй болгосон. 1 дүгээр түвшний хандах эрх дээр Ерөнхий нягтлан бодогч ажиллах эрхтэй бөгөөд засварлах, хаалт хийх, тайлан бэлтгэх, санхүүгийн давхар бичилтүүдийг хийж тааруулах зэрэг түвшинд ажилладаг болсон. 2 дугаар түвшний хандах эрхээр нягтлан бодогч, захиргаа, аж ахуй хариуцсан ажилтан нар ажиллах бөгөөд харилцах дансны хуулга боловсруулах, дараа тооцоо болон урьдчилж гарсан данснуудын хаалтын бичилтийг зөвхөн тухайн сардаа хийж гүйцэтгэх үүрэгтэй болсон. Ингэснээрээ компанийн Нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн үнэн зөв бүртгэл хөтлөлт, зөв тайлагналын эхлэл болсноороо үр дүнтэй ажил болсон юм.

Компанийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр олон арга хэмжээг авч ажилласан ба цаашид засаж, сайжруулах олон асуудал байгаа юм. Үүнд:

- Цаашид компанийн үйл ажиллагаа өргөжиж байгаатай холбоотойгоор ажилтнуудынхаа мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтуудыг зохиох, үйл ажиллагаатай холбоотой дүрэм журмуудыг илүү боловсронгуй болгоход анхаарч ажиллах хэрэгтэй байна. 2019 онд ажилтнуудаа мэргэжил, арга зүйн чиглэлээр чадавхжуулах сургалтуудыг түлхүү авах нь зүйтэй гэж үзэж байна.
- Компанийн хүний нөөцийн бодлогын баримт бичгийг боловсруулж гарган хүний нөөцийн программтай болох нэн шаардлагатай байгаа юм. Ингэснээр санхүүгийн Юникусс программтай холбогдон цагийн бүртгэл, ээлжийн амралт, цаг ашиглалт, цалин, шагнал урамшуулалт, хүний нөөцийн бүрдүүлэлт, хангалт зэрэг олон

- асуудлыг программчлан шийдвэрлэх боломжтой болох юм. Үүний үр дүнд аливаа үнэлгээ шударга явагдах үндэс тавигдана гэж үзэж байна.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолын төслийг хянах, тогтоолыг батлах үйл ажиллагааны дарааллыг тогтоох шаардлагатай байна.
 - Шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх зорилгоор зах зээлийн эрэлт хэрэгцээг судалж, газар тариалан, экспорт, эрчимжүүлсэн мал аж ахуй, гамшгийн даатгалын бүтээгдэхүүнийг иргэдийн хэрэгцээнд нийцүүлэн нэвтрүүлэхээр судлахад ажилтнуудад даатгалын бүтээгдэхүүний талаар мэргэжлийн сургалт, хичээл авах зайлшгүй шаардлага тулгарч байгаа тул сургалтад хамрагдах боломжийг бүрдүүлэх хэрэгтэй байгаа юм.
 - Маркетингийн 2018 оны төлөвлөгөөний биелэлтээс харахад нийт төсөвлөсөн төсвийн 60 хувийг зарцуулан хэмнэлттэй ажилласан байгаа юм. Хэмнэлт хийж чадсан ч сайжруулах боломжтой зүйлүүд байлаа. Өнгөрсөн жилийн хувьд хэвлэмэл материал, компанийн жилийн эцсийн тайлан болон видео бичлэгийг өөрсдийн гэрээт дизайнераар хийлгүүлсэн бол чанарын хувьд, өнгө үзэмж талаасаа илүү байх боломжтой байсан юм. Мөн мэргэжлийн камертай болсноор хөдөө орон нутгаар томилолтоор явах үед зураг бичлэг хийн түүнийгээ ашиглах боломжтой байгаа юм.
 - Цаашид давхар даатгалын бүтээгдэхүүнийг төрөлжүүлэх ажлыг сайн зохион байгуулах, мөн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсэгт шинэчлэн батлуулах хуулиудыг идэвхжүүлэх шаардлагатай байна.

Хянасан:

Дэд захирал
Ерөнхий хуульч
Андеррайтингийн газрын дарга
Бизнес хөгжил, төслийн газрын дарга
Хөрөнгийн удирдлага,
нөхөн төлбөрийн газрын дарга
Захиргаа, удирдлагын газрын дарга

О.Наранхүү
Г.Батзаяа
Т.Оюунбат
Б.Батбаяр

Д.Дуулал
Э.Ванчинхүү

Нэгтгэсэн:

Захиргаа, хүний нөөцийн ажилтан

Т.Уянга

-----oOo-----

“ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ” ХК
14251, Монгол Улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, 5 дугаар хороолол,
Чингисийн өргөн чөлөө-10Б байр,
“Бизнес тауэр”, 20 давхар
Э-шуудан: info@agreinsurance.mn
Вэб: www.agreinsurance.mn
Утас: 75770002
Факс: 75770003